

APU COMPANY

Absolute. Pure. Unique.

ЖИЛИЙН ТАЙЛАН 2022

 Absolute. төгс

 Pure. тунгалаг

 Unique. төгөлдөр

АГУУЛГА

01

БИДНИЙ ТУХАЙ

Эрхэм зорилго	5
Үзэл баримтлал	5
Үнэт зүйлс	5
Бидний тухай 1924-2022	6

02

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТУЗ-ийн даргын захидал	
Гүйцэтгэх захирлын захидал	
2022 оны үйл ажиллагааны хураангуй	
2022 оны санхүүгийн үйл ажиллагааны ерөнхий тойм	
2022 оны онцлох үйл явдал	
2022 оны зах зээлийн нөхцөл байдал	
2022 оны Экспортын тойм	
Гүйцэтгэх удирдлагын баг	
АПУ Групп компанийн бүтэц	
Үйлдвэрлэл, үйл ажиллагааны ололт амжилтууд	
Хүн төвтэй засаглалын бодлого	
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт	

03

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

9 Компанийн ерөнхий мэдээлэл	33
10 Хувьцаа эзэмшигчид	33
11 Төлөөлөн Удирдах Зөвлөл	35
13 Хувьцааны мэдээлэл	45
14 Ногдол ашгийн мэдээлэл	46
17 Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт, өөрийн үнэлгээ	48
21	
22	
24	
26	
30	

04

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН

АПУ компанийн 2022 оны тогтвортой хөгжлийн ажлуудыг зураглах нь	51
Энх тайван, шударга ёсыг цогцлоох	52
Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах	53
Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах	54
Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх	54
Тэгш бус байдлыг бууруулах	55
Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих	55
Хариуцлагатай хэрэглээг дэмжих	58

05

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

Дэлгэрэнгүй орлогын тайлан	65
Санхүү байдлын тайлан	66
Мөнгөн гүйлгээний тайлан	67
Өмчийн өөрчлөлтийн тайлан	69
Тайлагналын зарчим	70
Тайлбар толь	74

ЭРХЭМ ЗОРИЛГО



ҮЗЭЛ БАРИМТЛАЛ



Бид бүхий л түвшинд чанарыг эрхэмлэж, хэрэглэгч, харилцагч, хамтрагчдынхаа эрхэм сонголт байна.



Бид хүн, нийгэм ба эх дэлхийд ээлтэй үйл ажиллагаа явуулж, байгальд сөргөөр нөлөөлөх нөлөөллийг алхам бүртээ багасгаж, гэрэлт ирээдүйг хамтдаа цогцлооно.



Бид баяр хөөртэй, дахин давтагдашгүй, нандин сайхан мөчүүдийг түгээнэ.

ҮНЭТ ЗҮЙЛС



АМЖИЛТ ӨӨД ХАМТДАА

- Бид хамтын ажиллагаа, хамтын шийдвэр гаргалт, хүн бүрийн оролцоог бүрдүүлж, нээлттэй харилцааг эрхэмлэдэг.
- Харилцан итгэлцэл, хүндлэл, эерэг дулаан харьцааг бий болгон үр дүнтэй хамтран ажилладаг.
- “Би” бус “Бид” зарчмыг дээдэлдэг.
- Бид аливаад хамтдаа ялахын төлөө ажилладаг ба win-win зарчмыг дээдэлдэг.



БУСДЫГ ДЭЭДЛЭН ЭРХЭМЛЭ

- Хүнсний болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг эн тэргүүнд ханган ажилладаг.
- Бид байгаль орчиндоо ээлтэй үйл ажиллагаа явуулж, эх дэлхийгээ хайрлан дээдэлдэг.
- Бид нийгэмдээ үйлчилж, нийгмийн хөгжил дэвшилд өөрийн үнэтэй хувь нэмрийг оруулдаг.
- Бид хууль дүрмээ чандлан сахиж, шударга ёсыг эрхэмлэн ажилладаг.



СУРАЛЦ. НЭЭ. ХӨГЖ.

- Бид мэдлэг, ур чадварыг эрхэмлэн дээдэлдэг. Өөрийгөө болон бусдыг хөгжүүлэх нь ажилтан бүрийн эрхэм үүрэг.
- Хэрэглэгч, харилцагч, зах зээлийн талаарх мэдлэг, судалгаа, шинжилгээнд үндэслэн аливаа шийдвэрийг гаргадаг.
- Бид үргэлж шинийг судалж, эрэлхийлж, шинэ зах зээл, шинэ хил хязгаарыг нээхийг эрмэлздэг.



УЛАМЖЛАЛАА ХҮНДЭЛ, ШИНИЙГ БҮТЭЭ

- Бид үргэлж уламжлалаа дээдэлж, шинийг эрэлхийлж, шинэ шийдэл, шинэ бүтээгдэхүүн, шинэ үнэ цэнийг бүтээдэг.
- Ажилтан бүр нээлттэй санал санаачилга гаргаж, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэн ажилладаг.
- Бид бусдаас түрүүлж, бусдаас түргэн хөдөлдөг.



ҮЛГЭРЛЭН МАНЛАЙЛ

- Бид хааш тэмүүлж, юунд зорьж буйгаа мэддэг.
- Бид салбар, зах зээл бүртээ манлайлахын төлөө ажилладаг.
- Аливаад эзний ёсоор хандаж, бусдыгаа уриалан дууддаг.
- Хүн бүр манлайлагч байхыг хүсдэг, бас чаддагт итгэдэг.
- Хүн бүр бусдыг үлгэрлэн манлайлж, нөлөөлж нийгмийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэдэг.


БИДНИЙ ТУХАЙ

БИДНИЙ ТУХАЙ 1924–2022

Монгол Улсын хүнсний үйлдвэрлэлийн эхлэл суурь болж, тэртээ 1924 оноос хойш нэгэн зууны турш тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж буй АПУ компани нь дэлхийд өрсөлдөх үндэсний брэнд бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд экспортолж, улс эх орныхоо дотоодын эдийн засаг, нийгмийн хөгжлийн тогтвортой бодлогыг дэмжин өөрсдийн хүчин чармайлтаар түүчээлэн ажиллаж байна.

Бид Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг эрхэмлэн улс орны нийгэм, эдийн засагт хувь нэмрээ оруулж, урт хугацааны бизнесийн хөгжлийн суурийг бэхжүүлсээр байна.

1924



1924

“Архины онц эрхийг улсын санд авах тухай” дүрмийг анх баталсаны дагуу гар ажиллагаатай архи үйлдвэрлэх жижиг үйлдвэрийг энгийн шавар байшинд эхлүүлсэн нь одоогийн АПУ компанийн эх суурь болжээ.

1927

Чех улсын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар анх шар айргийг үйлдвэрлэж эхлэв.

2001

Төрийн өмчийн хорооны 2001 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 663 тоот тогтоолоор “АПУ ХК”-ийн нийт хувьцааны төрийн мэдэлд байсан 51 хувийн хувьцааг нийтийн дуудлага худалдаагаар арилжсанаар “АПУ ХК” хувийн өмчид бүрэн шилжив.

2009

2009 онд ХБНГУ-ын “Шмитт” компанийн орчин үеийн дэвшилтэт технологиор бүрэн тоноглогдсон хоногт 38000 литр “Альфа” буюу тансаг зэрэглэлийн спирт үйлдвэрлэх хүчин чадалтай “Натур Агро” \тухайн үеийн нэрээр\ үйлдвэрийг ашиглалтад оруулсан ба спиртийг тогтмол үйлдвэрлэж, компанийн архины үйлдвэрлэлийг жигд, тасралтгүй үйл ажиллагаагаар хангаж эхлэв.

2014

2014 онд 70 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч Германы GEA компанитай хамтран шинэ сүүний үйлдвэрийг ашиглалтад оруулав.

2017

2017 онд “АПУ” компани нь олон жилийн яриа, хэлэлцээрийн үр дүнд Нидерландын HEINEKEN компанийн Монгол дахь эзэмшлийн компаниудыг (М-БИ-СИ Азия Пасифик ХХК, Спирт Бал Бурам ХХК, СББ Трейд ХХК) өөртөө нэгтгэн хүчирхэг нэгдлийг бий болгов.

2021

АПУ ХК анхны нэг их наяд төгрөгийн үнэлгээтэй олон нийтийн компани болов.



2021

ТУЗ-ИЙН ДАРГЫН ЗАХИДАЛ



ЦАГААН ХУВЬСГАЛ – ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ

ЭРХЭМ ХҮНДЭТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ЭЭ,

Та бүхэнд АПУ ХК-ийн 2022 оны санхүү, үйл ажиллагааны үр дүнгийн талаар тайлагнан мэндчилж байна.

Өнгөрсөн онд хил дамнасан тээвэр худалдааны саатал, хэрэглээний үнийн өсөлт зэрэг сорилтууд үргэлжилсэн ч хамт олны маань хүчин чармайлт, харилцагч байгууллага, хэрэглэгчдийн дэмжлэгтэйгээр бид экспорт болон дотоодын борлуулалтаа өсгөж чадсан. Ийнхүү, тухайн жилийн санхүү, үйл ажиллагааны үр дүнд үндэслэн, нэгж хувьцаанд нийт 89 төгрөгийн ногдол ашиг хуваарилснаар АПУ Компани Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын манлайллаа дахин бататгалаа.

2022 онд Монгол Улс КОВИД-19 цар тахлыг даван туулснаа албан ёсоор зарлаж, нийгэм-эдийн засгийн бүхий л талбарт Шинэ сэргэлтийг цогцлоох зорилго тавьсан. Түүнчлэн, Монгол Улсын Ерөнхийлөгч Ухаагийн Хүрэлсүх “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг санаачилсныг хүнсний манлай үйлдвэрлэгч АПУ компанийн хамт олон бид талархан хүлээн авсан билээ.

Анх 2014 онд сүү, сүүн бүтээгдэхүүний салбарт хөл тавьсан бидний хувьд дотоодын үйлдвэрлэлийг дэлхийн стандартад хүргэж, малчдын амьжиргааг дэмжин, эх орныхоо тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах нь эрхэм зорилго юм. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Цагаан хувьсгал”-ыг түүчээлэн хэрэгжүүлэхийг бид ирэх жилүүдийн тэргүүлэх зорилтын нэгээр тодорхойлж, ханцуй шамлан ажилдаа орж байгааг хувьцаа эзэмшигч та бүхэндээ онцлон тэмдэглэхэд таатай байна.

Монгол орондоо “ЦАГААН ХУВЬСГАЛ” хийцгээе.

Пүрэвийн

Батсайхан

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЗАХИДАЛ

Эрхэм хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч, хамтран ажилладаг түнш байгууллагууд, хүндэт хэрэглэгч та бүхний амгаланг эрэн мэндчилье.

2022 онд дэлхий даяар нүүрлэсэн КОВИД-19 цар тахлын дараах үр нөлөө болон геополитикийн амаргүй нөхцөл байдлаас үүдсэн түүхий эд материалын ханган нийлүүлэлтийн хомсдол, үнийн огцом өсөлт, тээвэрлэлт, экспортын саад бэрхшээл зэрэг олон сорилттой тулгарсан хэдий ч бид харилцагч, хамтран ажиллагч түншүүд, ажилтнуудтайгаа хамтын хүчээр нэгдэн төлөвлөлтийн уян хатан шилжилтэд тулгуурлан ажиллалаа.

АПУ компани нь дэлхийд өрсөлдөх үндэсний компанийн хувиар олон улсын зах зээлд Монгол Улсыг төлөөлсөн брэнд бүтээгдэхүүнийг таниулах, ирээдүйн 5 жилд нийт борлуулалтын 20%-иас доошгүй хувийг экспортын орлогоос бүрдүүлэх том зорилтоо эрчимжүүлэн ажиллаж, ОХУ-д хийсэн экспортын хэмжээ өмнөх оны мөн үеэс 88%-иар өсгөж, БНХАУ-д борлуулалтын охин компаниа байгуулан, бизнесийн цар хүрээгээ тэллээ.

Дэлхий даяар үнийн өсөлтөөс үүдсэн эдийн засгийн нөхцөл байдал сорилт дүүрэн байсан ч бид улс эх орныхоо дотоодын үйлдвэрлэлд импортыг орлох бүтээгдэхүүний төрөлжилтөд анхаарч инновац хөгжүүлэлтийг олон улсын түвшинд гаргах суурь судалгаа, стратегид онцгойлон анхаарч сүү, сүүн бүтээгдэхүүний "Монгол сүү", "Монгол тараг", "Pro Plus" Лактозгүй сүү, "Pro Plus" Болгар Иогурт зэрэг уламжлалаа хадгалсан орчин үеийн хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцэхүйц шинэлэг брэндүүдийг зах зээлд танилцуулж, сүүний ханган нийлүүлэлт,

хүртээмжийг сайжруулах зорилгоор "Монгол Сарлаг - Гэр үйлдвэрлэл"-ийн төслөө эхлүүлж, малчдын тогтвортой амьжиргааг дэмжих хамтын ажиллагааг ийнхүү эхлүүллээ.

Бид хүн төвтэй засаглалын бодлогыг хэрэгжүүлэн, эрх тэгш, шударга, хүртээмжтэй байгууллагыг бий болгоход чиглэн ажилтнуудынхаа ажил амьдралын тэнцвэрт байдал, бие болон сэтгэл зүйн эрүүл мэндийг сайжруулах зорилгоор "APU LIFE" хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж, ажлын уян хатан цагийн системийг шинээр нэвтрүүлэн ажилтан бүрийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх тал дээр бодлогын хүрээнд анхаарч ажиллаа.

Мөн бид байгальд ээлтэй төсөл хөтөлбөрүүдээ үргэлжлүүлэн "Чи-Чадна – Шилээ дахин амьдрууля" төслийн хүрээнд шилний эргэлтийг 3 дахин нэмэгдүүлж, хариуцлагатай хэрэглээний соёлыг түгээх "Гайхамшигт жолооч – Уусан бол жолоо барьдаггүй" аяныг амжилттай эхлүүлээ.

Монгол Улсын хүнсний салбарын 99 жилийн түүхийг бүтээж, хамтын үнэ цэнийг бүтээлцсэн эрхэм хамтрагч, харилцагч, хэрэглэгч, ажиллагсад, хувьцаа эзэмшигч та бүхэндээ талархал дэвшүүлж, дэлхийд өрсөлдөх нэг зорилго дор нэгдэн хамтын ажиллагаагаа улам батжуулан хамтран ажиллана гэдэгт итгэл дүүрэн байна.

Цэвээнжавын  ЭРДЭНЭБИЛЭГ

2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ



Тэрэлж

АЛТАН ГАГНУУР



Хvний биеийн алжаал, ядаргааг тайлах тамир тэнхээг сайжруулахад тустай.



ГАНГА



Ганга өвс нь амьсгалын дээд, доод замын халдварт өвчнүүдэд нэн сайн.

ЦЭЭНИЙ ҮНДЭС

нь төв мэдрэлийн тогтолцоог тайвшруулж, дархлааг дэмжинэ.



ҮНДЭСНИЙ БАХАРХАЛТ УНДАА

2022 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ТОЙМ

Тоон үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан	Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан	Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан	Өөрчлөлт %
		2022	2021 (restated)	2021	
БОРЛУУЛАЛТЫН ТОО ХЭМЖЭЭ	мян. литр	158,800	170,210	170,210	7% ↓
ОРЛОГО ҮР ДҮН					
Цэвэр борлуулалтын орлого	сая.төг	850,240	678,164	678,164	25% ↑
Үйл ажиллагааны ашиг	сая.төг	164,452	197,828	197,893	17% ↓
Тайлант үеийн цэвэр ашиг	сая.төг	125,898	153,621	153,686	18% ↓
БАЛАНС					
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	351,152	251,637	251,637	40% ↑
Эргэлтийн бус хөрөнгө	сая.төг	490,982	364,889	365,575	35% ↑
Нийт хөрөнгө	сая.төг	842,134	616,525	617,212	37% ↑
Нийт өр төлбөр	сая.төг	208,557	112,226	112,226	86% ↑
Нийт эздийн өмч	сая.төг	633,577	504,300	504,987	26% ↑
Нийт эздийн өмч ба өр төлбөр	сая.төг	842,134	616,525	617,212	37% ↑
МӨНГӨН ГҮЙЛГЭЭ					
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	112,646	181,564	181,647	38% ↓
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(92,777)	(65,511)	(65,594)	41% ↑
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(60,639)	(102,770)	(102,770)	41% ↓
Бусад мөнгөн гүйлгээ	сая.төг	1,857	(65)	(65)	2966% ↓
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(38,913)	13,219	13,219	394% ↓
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	сая.төг	77,278	64,059	64,059	21% ↑
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	сая.төг	38,365	77,278	77,278	50% ↓
ТАТВАР ТӨЛӨЛТ					
Онцгой албан татвар	сая.төг	196,919	211,313	211,313	7% ↓
Нэмэгдсэн өртгийн албан татвар	сая.төг	71,989	69,359	69,359	4% ↑
Бусад	сая.төг	128,588	84,338	84,338	52% ↑
Нийт татвар төлөлт	сая.төг	397,495	365,010	365,010	9% ↑
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ					
Нийт хөрөнгө оруулалт	сая.төг	86,529	69,151	69,151	25% ↑

2022 ОНЫ

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

"МОНГОЛ САРЛАГ" ГЭР ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨСӨЛ



Сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь шингэн сүүний нийлүүлэлт, тээвэр логистикоос шууд хамааралтай бөгөөд малчин өрхийн амьжиргааг дэмжих анхан шатны боловсруулах үйлдвэрлэлийг бий болгоход чиглэн АПУ Дэйри Монгол сүүний үйлдвэр нь "МОНГОЛ САРЛАГ"- Гэр үйлдвэрлэлийн төслөө Архангай аймгийн Чулуут суманд 2022 онд эхлүүлээ.



ГАЙХАМШИГТ ЖОЛООЧ УУСАН БОЛ ЖОЛОО БАРЬДАГГҮЙ

"ГАЙХАМШИГТ ЖОЛООЧ УУСАН БОЛ ЖОЛОО БАРЬДАГГҮЙ"

"АПУ" ХК нь нийгмийн манлайллын "Соёлоор гоёно" төслийн дэд хэсэг болгон хэрэгжүүлж байгаа билээ. Энэ хүрээнд компанийн тогтвортой хөгжлийн бодлогын нэг хэсэг болох "Хариуцлагатай хэрэглээ"-г бий болгох зорилгоор замын хөдөлгөөний аюулгүй байдал, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохын эсрэг "Гайхамшигт жолооч – Уусан бол жолоо барьдаггүй" хөтөлбөрийг хэрэгжүүлж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохын хор уршгийг нийгэмд таниулах, зөрчлөөс сэргийлэх арга зам, жолоодлогын үйлчилгээний талаарх мэдлэг, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр "АПУ" ХК, Тээврийн Цагдаагийн алба, "UBCab" байгууллагуудтай хамтран ажиллаж байна.



ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭ

АПУ ХК-ийн нийгмийн эерэг өөрчлөлтийн "Соёлоор Гоёно" төсөл #SocialiseResponsibly уриатайгаар дэлхийд Монголыг сурталчлах зорилготой "Spirit of Gobi" Art and Music Festival-ыг 2022 онд амжилттай зохион байгуулсан. Энэ хүрээнд залуус, нийгэм, олон нийт, хэрэглэгчдийн дунд хэрэглээний соёлыг төлөвшүүлж, байгальд ээлтэй, хариуцлагатай, зөв зохистой хэрэглээг сурталчлан таниуллаа.



ЭКСПОРТЫН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

АПУ компани нь 2022 он гарсаар дэлхийн зах зээлд үндэсний брэнд бүтээгдэхүүнээ таниулах ажлаа улам эрчимжүүлэн ОХУ, БНХАУ, БНСУ, БНПУ, Тайландын Хаант Улс-руу бүтээгдэхүүнээ экспортолж байна.



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

АПУ ХК болон "Калтенберг" брэндийн шар айраг үйлдвэрлэгч "Кониг Людвиг Интернэйшнл" компани хамтын ажиллагаагаа дахин 5 жилээр сунгаж, "Калтенберг" шар айргийг тусгай зөвшөөрлийн дагуу дотооддоо үйлдвэрлэх эрхээ ийнхүү бататгалаа. Ингэснээр олон улсад алдартай "Калтенберг" шар айргийн шинэ нэр төрөл болох "Kaltenberg light 3.8%" -ийг зах зээлд шинээр үйлдвэрлэн нэвтрүүллээ.



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх тэргүүтэй албаны төлөөлөл АПУ ХК-ийн үйлдвэрүүдээр зочилж, үйлдвэрлэлийн технологи, ноу-хау, аюулгүй ажиллагаатай танилцлаа. Энэ үеэр АПУ Дэйри Монгол Сүүний үйлдвэрийн "Монгол Сарлаг- Гэр үйлдвэрлэл" төслийн нээлтийн үйл ажиллагаатай танилцан, АПУ ХК-ийн дэлхийд өрсөлдөх үндэсний брэнд бүтээгдэхүүний хөгжүүлэлт, экспортын өнөөгийн нөхцөл байдал, голлох өсөлт, олон улсын чанар стандарт, хамтын ажиллагаатай дэлгэрэнгүй танилцлаа.

ӨӨРИЙН ЗОХИЦЛЫГ БҮТЭЭ.



2022 ОНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

АРХИН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ

2022 онд Монгол Улсын архин бүтээгдэхүүний зах зээл биет хэмжээгээр

30 сая литр хүрсэн байна. АПУ ХК нь 2022 оны байдлаар нийт 21 брэндийн бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд үйлдвэрлэн нийлүүлж байна..

СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ

Монгол улсын сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээл биет хэмжээгээр

93 сая литр хүрсэн байна. Апу Дэйри ХХК нь 2022 оны байдлаар сүү сүүн бүтээгдэхүүний нийт 6 брэндийн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд үйлдвэрлэн нийлүүлж байна.

ШАР АЙРГИЙН ЗАХ ЗЭЭЛ

2022 онд Монгол улсын шар айргийн зах зээл биет хэмжээгээр

113 сая литр хүрсэн байна. 2022 оны байдлаар нийт 11 брэндийн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд үйлдвэрлэн нийлүүлж байна.

ДАРСНЫ ЗАХ ЗЭЭЛ

2022 онд Монгол улсын дарсны зах зээл биет хэмжээгээр

4 сая литр хүрсэн байна. 2022 оны байдлаар нийт 10 брэндийн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд үйлдвэрлэн нийлүүлж байна.

УС, УНДАА, ШҮҮСНИЙ ЗАХ ЗЭЭЛ

2022 онд Монгол улсын ус ундааны зах зээл биет хэмжээгээр

477 сая литр хүрсэн байна. 2022 оны байдлаар нийт 5 брэндийн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд үйлдвэрлэн нийлүүлж байна.

ИМПОРТЫН ВИСКИ БОЛОН БУСАД ЗАХ ЗЭЭЛ

2022 онд Монгол Улсын импортоор орж ирж байгаа виски болон бусад бор спиртэн бүтээгдэхүүний нийт зах зээл

1 сая литр хүрсэн байна. 2022 оны байдлаар нийт 12 брэндийн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд үйлдвэрлэн нийлүүлж байна.




2022 ОНЫ ЭКСПОРТЫН ТОЙМ


АПУ компани нь 2022 он гарсаар дэлхийн зах зээлд үндэсний брэнд бүтээгдэхүүнээ таниулах ажлаа улам эрчимжүүлэн ОХУ, БНХАУ, БНСУ, БНПУ, Тайландын Хаант Улс-руу бүтээгдэхүүнээ экспортолж байна.


2022 ОНЫ ОНЦЛОХ ЭКСПОРТЫН ҮЙЛ ЯВДАЛ:


-  ОХУ дахь экспортын хэмжээ өмнөх оны мөн үеэс **88%**-иар өсөв.
-  БНХАУ-д борлуулалтын охин компани байгуулж, бизнесийн цар хүрээгээ тэллээ.
-  БНСУ-ын алдарт GS25 сүлжээ дэлгүүрийн 1000 салбаруудаар “Алтан Говь” шар айргийг борлуулж эхэллээ.
-  Тайландын Хаант Улсын Зүүн Өмнөд Азийн тэргүүлэгч “King Power” Duty Free буюу татваргүй барааны дэлгүүрүүдээр “Чингис Хаан” брэндээ борлуулж эхэллээ.
-  Польш улсын сүлжээ дэлгүүрүүдээр АПУ ХК-ийн “Чингис Хаан” брэнд амжилттай борлуулагдаж эхэллээ.


2022 ОНЫ ЭКСПОРТЫН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ




 ИТАЛИ улс, Комо хот: FUORI CONCORSO, тансаг зэрэглэлийн брэндүүдийг танилцуулах арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.


 ПОЛЬШ улс: ПОЛЬШ улс, дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулагдсан “Монголын нэг өдөр” өдөрлөгт оролцов.


 БОЛГАР улс, София хот: Болгар Улсын Аялал Жуулчлалын яамны ивээл дор зохион байгуулагдсан 38 дахь удаагийн “Holiday & Spa International Fair” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол улсаас төлөөлж оролцлоо.


 ПродЭкспо 2022 үзэсгэлэн 2-р сарын 7-11-ний хооронд Москва хотод зохион байгуулагдаж буй “Продэкспо 2022” үзэсгэлэнд Монгол улсаас АПУ ХК оролцлоо.


 ОХУ, Москва хот: ОХУ -ын хамгийн нэр хүнд бүхий өндөр зэрэглэлийн “Gentlemen Private Club” -тай хамтран “Чингис Хаан” брэндийн нэрэмжит арга хэмжээг зохион байгуулав.



 ТАЙЛАНД улс, Бангкок хот: Эрхэмсэг Хатан хаан Сириkit-ийн нэрэмжит “Тайланд торго олон улсын загварын долоо хоног” үйл ажиллагаанд “Чингис Хаан” брэндийг сурталчлан таниулав.

 АНУ, Вашингтон хот: Монгол улсаас АНУ-д суугаа Элчин Сайдын Яамтай хамтран “Chinggis Khan Golf tournament” -ийг зохион байгууллаа.

 СОЛОНГОС улс, Илсан хот: GS25 ая тухтай дэлгүүрээс жил бүр зохион байгуулагддаг “GS25 Beer & Music” хөгжмийн фестивалд “Алтан Говь” шар айргийг сурталчлан таниулав.

 ОХУ, Москва хот: ОХУ-ын алдарт жүжигчин Светлана Бондарчукийн нэрэмжит “Action auction charity dinner” үйл ажиллагаанд АПУ ХК хамтран ажиллаж, ОХУ-ын шоу бизнесийн одуудад “Чингис Хаан” брэндийг сурталчлан таниулав.

БҮХ ЗҮЙЛ ЗОХИЦОЛ



ГҮЙЦЭТГЭХ ДЭД УДИРДЛАГЫН БАГ



**Цэвээнжавын
ЭРДЭНЭБИЛЭГ**
Гүйцэтгэх захирал



**Дандарова
АРИУНА**
Экспорт эрхэлсэн захирал



**Батсайханы
ЦАЦРАЛ**
Борлуулалт, маркетинг
эрхэлсэн захирал



**Жаргалсайханы
ИЧИНХОРЛОО**
Захиргаа, Хүний нөөц
эрхэлсэн захирал



**Добрев
НИКОЛАЙ**
Үйлдвэрлэл, үйл ажиллагаа
эрхэлсэн захирал



**Гончигийн
ЭНХБИЛЭГ**
Санхүү эрхэлсэн захирал,
Төслийн удирдлагын
захирал



**Галсумъяагийн
БАЯРМАГНАЙ**
АПУ Дэйри ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



**Батсайханы
ГАНТИГ**
Стратеги эрхэлсэн захирал

АПУ ГРУПП КОМПАНИЙН БҮТЭЦ

APU COMPANY

Absolute. Pure. Unique.



Бүтцэд гарсан өөрчлөлт:

АПУ ХК-ийн экспортын үйл ажиллагааг тэлэх зорилгоор 100%-ийн хөрөнгө оруулалттай охин компани болох Эйпиюү трейд (Inner Mongolia Airyou Trade) ХХК-ийг БНХАУ-ын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулж, 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр бүртгүүлсэн.



ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОЛОЛТ АМЖИЛТУУД

➤ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

2022 онд аюулгүй ажиллагааны өндөр гүйцэтгэлтэй ажиллаж 200,000 хүн/цаг тутамд ноогдох ослын давтамжийг 0.1 буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10% бууруулж, нийт ажилтнуудад Хайнекен группийн шинэчлэгдсэн “Амь насаа хамгаалах 12 амлалт” дүрмийг таниулсан сургалтыг амжилттай зохион байгууллаа.

➤ ҮЙЛДВЭР ТӨЛӨВЛӨЛТ

2022 онд цар тахлын дараах шилжилт, ОХУ, Украин улс хоорондын дайны үеийн үйлдвэрлэл, үйл ажиллагааны уян хатан, эрсдэл тооцсон хөрвөх чадвартай төлөвлөлтөд анхаарч ажиллав..

➤ ҮЙЛДВЭРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ШИНЭЧЛЭЛ

Бид бүтээгдэхүүний тасралтгүй шинэчлэл, нийлүүлтэнд анхаарч “Ус ундааны савлах үйлдвэрийн ПЭТ савлагааны шугам дээр 8800 лонх/цаг үлээх машиныг амжилттай суурилууллаа. Үүний үр дүнд “Ус, ундаа үйлдвэрлэлийн хүчин чадал 2-3 дахин нэмэгдэж, хөдөлмөрийн бүтээмж дээшиллээ. Мөн шар айргийн үйлдвэрт “HGB” буюу өндөр нягтралтай пиво чанах, шингэрүүлэх технологийг амжилттай нэвтрүүлж, үйлдвэрийн хүчин чадлыг 20%-иар нэмэгдүүллээ.

➤ БҮТЭЭМЖИЙН УДИРДЛАГЫН СИСТЕМ

Үйл ажиллагааны тасралтгүй сайжруулалтын нэг хэсэг болох “Бүтээмжийн Удирдлагын Систем”-ийн хүрээнд 2022 онд тус системийн аргачлалыг ашиглан нийт 135 баг ажиллаж, гүйцэтгэлээ сайжруулж, бүтээмжээ нэмэгдүүлэн, процессын алдагдлыг бууруулан ажиллаа. Үүний хүрээнд TPM шагнал, урамшууллын журмын дагуу давхардсан тоогоор нийт 563 ажилтнуудыг урамшуулж, “Бүтээмжийн Удирдлагын Систем”-ийн хэрэгжилтийн үйл явц, түвшнийг “TPM Maturity” аудитад шалгуулж, өмнөх амжилтаа ахиуллаа.

➤ “ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АКАДЕМИ”

АПУ ХК нь нийт 2000 гаруй ажилтантай бөгөөд үүний 1000 гаруй нь “Үйлдвэрлэл, үйл ажиллагаа”-ны газарт ажиллаж байна. Иймд үйлдвэрлэл, үйл ажиллагааны ажилтнуудын сургалтын хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжлийн сургалтын цогц бодлогыг хэрэгжүүлэн “ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АКАДЕМИ” – ийг төслийн хүрээнд хэрэгжүүлэн, ажиллаж эхэллээ.



➤ ЧАНАРЫН УДИРДЛАГА, ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

АПУ групп компанийн хэмжээнд Олон улсын Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001, Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо FSSC 22000 стандартуудын хэрэгжилтийг дэлхийд тэргүүлэгч SGS компаниар амжилттай шалгуулж дахин баталгаажууллаа.

АПУ ХК-ийн охин компани болох СББ ХХК-ийн 50 жилийн түүхэнд анх удаа “Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо FSSC 22000” стандартын шаардлагыг бүрэн хангаж, олон улсад бүртгэлтэй боллоо.

АПУ ХК нь Хайнекен компанийн олон улсын шинжилгээний холбоонд нэгдэж, шар айргийн төрлийн бүтээгдэхүүнд 2 сар тутамд харьцуулсан шинжилгээ хийлгүүлэн чанарыг баталгаажуулж байна.

Бельги улсын нийслэл Брюссель хотноо зохион байгуулагдсан олон улсын “Monde Selection Quality Award” арга хэмжээнд “EVOK” болон “ELIX” брэндүүд оролцож “GOLD” шагналыг хүртлээ. Тус арга хэмжээ нь нэр хүндтэй шинжээчдийн багийн үнэлгээнд суурилдаг бөгөөд АПУ ХК-ийн бүтээгдэхүүн “GOLD” шагнал хүртсэн нь брэндийн чанар дэлхийн түвшинд хүрснийг илтгэх нэр хүндийн баталгаа болж байна.

➤ ДИЖИТАЛ БОЛОН ТЕХНОЛОГИ

Үйлдвэрлэл үйл ажиллагааны “Дижитал болон технологи” стратегийн пилларын хүрээнд үндсэн процессыг автоматжуулан бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор “Brew max”, “Digital TPM”, “Power BI” зэрэг төслүүдийг хэрэгжүүлж ажиллав.

➤ ШИНЭ ЛОЖИСТИК ТӨВИЙГ АШИГЛАЛТАНД ОРУУЛЛАА.

Монгол улсын хэмжээнд хоёр дахь бүрэн автомат агуулах болох Баруун бүсийн ложистик төвөө АПУ ХК ашиглалтад орууллаа. Ингэснээр АПУ групп компанийн хэмжээнд агуулахын нийт хүчин чадал 30%-иар нэмэгдэж, Улаанбаатар хот болон орон нутгийн баруун бүсийн 1300 гаруй харилцагчийн захиалгыг хурдан шуурхай хүргэх боломжтой боллоо..

ХҮН ТӨВТЭЙ ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

АПУ ХК нь хүн төвтэй засаглалын бодлогын хүрээнд байгууллага болон ажилтны чадамжийг өсгөх, байгууллагын соёлд анхааран ажиллахад таатай газрыг бий болгох, гүйцэтгэлийн удирдлагыг

сайжруулан ажилтнуудын бүтээмжийг нэмэгдүүлэх, эрх тэгш, шудрага, хүртээмжтэй байгууллагыг бий болгоход чиглэн ажиллаж байна.

“APU LIFE” ХӨТӨЛБӨР

АПУ ХК нь ажил, амьдралын тэнцвэрт байдлыг хадгалах, ажилтан бүрийн бие болон сэтгэл зүйн эрүүл мэнддээ анхаарах боломжийг олгох зорилгоор “APU Life” хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлээ. Энэхүү хөтөлбөр нь сэтгэл санаа, ажил мэргэжил, бие махбодь, нийгмийн сайн сайхан байдал гэсэн үндсэн дөрвөн чиглэлийн хүрээнд хэрэгжсэн бөгөөд үүний хүрээнд “АПУ ИОГ”-ийн хичээл, “АПУ МАРАФОН” гүйлтийн арга хэмжээ, “Tiger Time”, “АПУ үйлдвэрлэлийн аялал”, “ARE U OK”- сэтгэл зүйн эрүүл мэнддээ хайрлах аян, “Хөхүүл ээжийн булан”, “Хүүхдэд зориулсан өрөө”, “APU Talk” зэрэг ажилтнуудыг идэвхжүүлэх цогц хөтөлбөрүүдийг амжилттай зохион байгууллаа.

“APU Life” хөтөлбөрийн үр дүнд ажил, амьдралын тэнцвэрт байдлаа хадгалах, хувь хүний бие болон сэтгэл зүйн эрүүл мэнддээ анхаарах нь хичнээн чухал болохыг сурталчлан таниулж, ажилтан бүр өөрийн арга туршлага, сонирхол хоббигоо бусадтайгаа нээлттэй хуваалцах боломж олгосноороо давуу юм.



УЯН ХАТАН АЖЛЫН ЦАГ

2022.04.01-ээс эхлэн уян хатан цагийн хуваариар ажиллах боломжтой боллоо.

(Үйлдвэрлэл, Борлуулалт даган ажилладаг ажлын байр хамаарахгүй болно.)



АПУ ХК нь замын хөдөлгөөний оргил цагийн ачааллын улмаас цаг алдалгүй ажилдаа ирэх, буцах хугацаагаа илүү үр ашигтай байдлаар зохицуулах зорилгоор 2022 оны 04 сараас эхлэн “Уян хатан ажлын цаг”-ийн зохицуулалтын сонголтыг бий болгон хэрэгжүүлж эхэллээ. Ингэснээр ажилтнууд ажлын цагт баригдахгүйгээр 07:00 –10:00 цагийн хооронд ажилдаа ирж, 16:00-19:00 цагийн хооронд тарах боломжтой болсон юм. Нийт ажилтнуудын 20.9% нь уян хатан цагаар ажиллаж байна.



ХӨХҮҮЛ ЭЭЖИЙН БУЛАН

Хөхүүл эхчүүдэд зориулсан жишиг буланг “Mommy’s corner” нэртэйгээр АПУ компанийн нийт 3 байршилд шинээр байгууллаа. Ингэснээр компанид ажиллаж буй хөхүүл эхчүүдийн хэрэгцээг хангаж, бүтээмжийг дээшлүүлж, улмаар соёл, ажлын байрны таатай орчныг бий болгож байна. Эхийн сүүгээр хооллох, ажлын байранд хөхөө саах орчныг бүрдүүлэх нь хүн амын эрүүл мэнд, ирээдүй хойч болсон үр хүүхдийн эрүүл өсөлтөд эергээр нөлөөлсөн ажил болно гэж итгэж байна.

АПУ "МЕНТОРШИП ХӨТӨЛБӨР"-2022

АПУ ХК нь шинэ залуу ажилтнуудад карьер төлөвлөлт, хувь хүний хөгжил болоод мэргэжлийн зөвлөгөө, менторинг болон көүчинг үйлчилгээг ажлын байрнаасаа авах боломжийг бүрдүүлэх зорилгоор "Менторшип Хөтөлбөр"-ийг хоёр дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.





2022 оны Менторшип хөтөлбөр нь тасралтгүй суралцах соёлыг түгээх хувь хүний авьяас, ур чадварыг таньж илрүүлэх, мөн хөгжүүлэх замаар багийн болоод тухайн хувь хүний гүйцэтгэлийг нэмэгдүүлэх үндсэн гурван зорилготойгоор нийт 8 сарын хугацаанд АПУ компанид хэрэгжсэн бөгөөд хөтөлбөрт оролцогчид PwC зөвлөх компанийн зүгээс зохион байгуулсан төрөл бүрийн сургалтад хамрагдахын зэрэгцээ удирдах багийн гишүүдээс бүрдсэн Менторуудынхаа мэдлэг, туршлагаас давхар суралцаж, компанид түгээмэл тохиолдож болохуйц тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий бичил төслүүдийг нийт 3 сарын хугацаанд хэрэгжүүлж, үр дүнгээ танилцуулан, шилдэг төслөө шалгаруулсан нь өмнөх жилүүдээс онцлог болсон юм.



СОНИРХОГЧДЫН КЛУБ

АПУ компани нь ажилтнуудынхаа сонирхол хоббиг дэмжиж, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлж, хамт олны хоорондын уялдаа холбоог сайжруулан, оролцоог нь нэмэгдүүлэх үүднээс анх 2015 онд "Сонирхлын клуб"-үүдийг байгуулсан. Энэхүү сонирхлын клубүүд нь "APU HIKING, APU PHOTOSHOOTING, APU MUSIC, APU COOKING" зэрэг 13 гаруй төрлийн спортын төрлөөр байгуулагдсан бөгөөд ажилтан бүрд өөрийн сонирхлын дагуух клубт хамрагдаж, өөрийн сонирхол хоббигоо хөгжүүлэх боломжийг олгож буйгаараа давуу юм.



"АПУ Академи" ба Чиг үүргийн Академиуд

"АПУ Академи"-ийн 2025 он хүртэлх стратеги, бодлогын баримт бичгийг боловсруулсан. Энэ хүрээнд компанийн үнэт зүйлс, үзэл баримтлалыг таниулсан сургалт болон хувь хүний хөгжилд чиглэсэн "Багаар ажиллах чадвар", "Манлайллын чадвар", "Асуудал шийдвэрлэх чадвар" зэрэг ерөнхий ур чадварын сургалтуудыг дотооддоо амжилттай зохион байгууллаа. Мөн АПУ Академи нь чиглэл бодлогоо оновчлон 2022 оны турш Чиг үүргийн академиудыг бий болгон хэрэгжүүлэн ажиллаа. Чиг үүргийн академи нь ажилтны мэргэжлийн талын ур чадварыг нэмэгдүүлэх, олон улсын мэдлэг туршлагыг нэвтрүүлэх эрхэм зорилготой бөгөөд Үйлдвэрлэл, Үйл ажиллагааны академи, Санхүүгийн академи, Хүний нөөцийн академиуд нь сургалт хөгжлийн үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна.



АПУ Академи нь тус чиг үүргийн академиудын дотоод сургагч багш нарыг бэлтгэх хөтөлбөрийг 4 удаа зохион байгуулж нийт 72 Сургагч багшийг амжилттай төгсгөсөн. Чиг үүргийн академиуд тус тус бүр сургалтын хөтөлбөрийг боловсруулан 2023 онд ажилтнуудын ур чадварын зөрүүг тодорхойлж үүн дээр суурилсан оновчтой сургалт хөгжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллахаар зорьж байна.



БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

ХАТУУЛАГ БАГАТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН

Эх орны шилэгдмэл сортын улаан буудайгаар дэлхийн өндөр түвшний стандартын дагуу боловсруулсан Монголын анхны крафт шар айраг болох IPA/PA Hops & Rocks, Kaltenberg Leicht хатуулаг багатай шинэ төрлийг зах зээлд шинээр танилцууллаа. Мөн Дэлхийн шилдэг сайдер төрлийн брэнд болох Strongbow cider-г Gold apple & Rose apple 2 төрлийн жимсний амттайгаар импортлон оруулж ирэв.



ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭ

Монгол орны эрүүл хөрсөнд ургасан дээд зэрэглэлийн улаанбуудайгаар олон улсын түвшний өндөр ур чадвартай мэргэжилтнүүдийн боловсруулсан инновац шингэсэн технологийн дагуу олон улсад өрсөлдөх брэнд бүтээгдэхүүнийг дотоодын болон олон улсын зах зээлд шинээр танилцууллаа.



ИННОВАЦ – ШИНЭЧЛЭЛ

Эх орныхоо эмийн ургамлыг үндэсний бахархалт брэнд болтол нь хөгжүүлэн боловсруулж, шинэ инновац шингээн орчин үеийн технологийн дагуу үйлдвэрлэсэн брэндүүдээ хэрэглэгчдэд зориулан шинэ савлагаатайгаар худалдаанд гаргалаа.

Инновац, шинэчлэл шингэсэн эх орны бүтээгдэхүүн.



УЛАМЖЛАЛ- ШИНЭЧЛЭЛ

Уламжлал, шинэчлэл хослуулан бүтээсэн хүн амын дархлааны амин чухал хэрэгцээг хангах эрүүл мэндийн брэнд бүтээгдэхүүний хөгжүүлэлт, чанар стандартыг олон улсын түвшинд хүргэж, хэрэглэгч олондоо зориулан олон төрлөөр худалдаанд гаргалаа.

Уламжлал, шинэчлэл хослуулсан эрүүл мэндийн бүтээгдэхүүн



КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Оноосон нэр:
АПУ

Хэлбэр:
Нээлттэй хувьцаат компани

Регистрийн дугаар:
2702673

Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:
Монголын Хөрөнгийн бирж


МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал:
I

Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг:
1,064,181,553


Бизнесийн үндсэн үйл ажиллагааны салбар:

- **Архины үйлдвэрлэл**
- **Шар айрагны үйлдвэрлэл**
- **Спиртийн үйлдвэрлэл**
- **Ундаа, ус, жүүсний үйлдвэрлэл**
- **Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл**

Хувьцаа эзэмшигчдийн тоо¹



Хувьцаа эзэмшигчдийн бүтэц



¹ ҮЦТХТ ХХК-аас гаргасан 2022.12.31-ний өдрийн байдлаарх үнэт цаасны төвлөрлийн судалгааны мэдээлэл

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

➤ **Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид²**

	Хувьцаа эзэмшигч	2021 оны эцэс		2022 оны эцэс	
		Хувьцааны тоо ширхэг	Нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь
1	Шунхлай Холдинг ХХК	596,229,642	56.03	596,229,642	56.03
2	Heineken Asia Pacific Pte Ltd	266,091,981	25.00	266,091,981	25.00
3	Steppe Beverage KFT	142,870,636	13.43	115,769,993	10.88
4	Бусад	58,989,294	5.54	86,089,937	8.09

Өмнөх онтой харьцуулбал нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Steppe Beverage KFT-ийн эзэмшлийн хувь 2.55%-аар буурсан байна.

➤ **Хувьцаа эзэмшигчдийн хурал**

АПУ ХК-ийн эрх барих дээд удирдлага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022.04.29-ний өдөр Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандийн гудамж 39, Корпорейт Хотел энд Конвеншн Цэнтрийн 4 давхарт байрлах Концерт холл танхимд 94.33%-ийн ирцтэй хуралдаж, дараах шийдвэрүүдийг гаргав. Үүнд:

- 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан **"АПУ групп компани 2021 онд тавьсан зорилтуудаа бүрэн биелүүлж, амжилттай ажилласан"** хэмээх дүгнэлтийг батлав.
- ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгов.
- ТУЗ-ийн ердийн гишүүдээр П.Батсайхан, Б.Батбаяр, Сергей Громов, Д.Миеэгомбо, Кеннет Чу, Сэн И-Ин, хараат бус гишүүдээр Ё.Гэрэлчулуун, О.Одбаяр, Ж.Үнэнбат нарыг 3 жилийн хугацаатай сонгов.

² ҮЦТХТ ХХК-аас гаргасан 2022.12.31-ний өдрийн байдлаарх үнэт цаасны төвлөрлийн судалгааны мэдээлэл

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт ТУЗ компанийг удирддаг.

➤ **ТУЗ-ийн бүрэлдэхүүн**

Тайлант хугацаанд 2022.04.29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн бүрэн эрхийг дуусгавар болгож, ТУЗ-ийн шинэ бүрэлдэхүүнийг сонгосноор дараах өөрчлөлт орсон. Үүнд:

ТУЗ нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн дотоод дүрэм журамд заасан АПУ ХК-ийн ТУЗ-ийн болон түүний охин, хараат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлдэг.

- ТУЗ-ийн ердийн гишүүнээр Томас Холландын оронд Доржийн Миеэгомбо сонгогдов.
- ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Өлзийдэлгэрийн Батбаярын оронд түр томилогдсон Одончимэдийн Одбаярыг нөхөн сонгов.



ПҮРЭВИЙН БАТСАЙХАН
ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дарга
Инженер мэргэжилтэй
Шунхлай холдинг ХХК-ийн Ерөнхийлөгч
2002 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн дарга
Хувьцаа эзэмшил: 0.08%



БҮРЭНТОГТОХЫН БАТБАЯР
ТУЗ-ийн ердийн гишүүн
Эдийн засагч мэргэжилтэй
Шунхлай групп ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал
2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.05%



СЕРГЕЙ ГРОМОВ
ТУЗ-ийн ердийн гишүүн
Инженер мэргэжилтэй
Монгол Даатгал ХК-ийн ТУЗ-ийн дарга
2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.00%



КЕННЕТ ЧУ
ТУЗ-ийн ердийн гишүүн
Няглан бодогч, менежмент мэргэжилтэй Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийг хариуцсан Гүйцэтгэх захирал
2018 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.00%



СЭН И-ИН
ТУЗ-ийн ердийн гишүүн
Хуульч мэргэжилтэй
Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийн Хууль эрхзүй хариуцсан захирал
2020 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.00%



ДОРЖИЙН МИЕЭГОМБО
ТУЗ-ийн ердийн гишүүн
Хуульч мэргэжилтэй
"ЕС" ХХН-д зөвлөх
2022 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.00%



Одончимэдийн ОДБАЯР
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Багш, эрх зүйч мэргэжилтэй
Ард даатгал ХК, Ард холдинг ХХК, Монгол шуудан ХК-уудын ТУЗ-ийн гишүүн
2021 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.00%



ЁНДОН-ОЙДОВЫН ГЭРЭЛЧУЛУУН
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Эдийн засагч мэргэжилтэй
Нээлттэй хот ТББ-ын үүсгэн байгуулагч
2017 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.00%



ЖИГЖИДИЙН ҮНЭНБАТ
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Эдийн засагч мэргэжилтэй
2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.00%



ЧАДРААБАЛЫН АРИУНСАН
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

➤ **ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан**

ТУЗ нь 2022 онд танхимаар, танхим-цахим хосолсон, эчнээ санал хураалтын хэлбэрээр нийт 10 удаа 100%-ийн ирцтэй хуралдав.

	Огноо	Ирц
1	2022.01.25	100%
2	2022.02.17	100%
3	2022.03.18	100%
4	2022.04.21	100%
5	2022.05.06	100%
6	2022.05.18	100%
7	2022.08.03	100%
8	2022.10.12	100%
9	2022.10.24	100%
10	2022.12.07	100%
	Нийт	100%

Дээрх хурлаар нийт 52 тогтоол шийдвэр гаргасныг дэлгэрэнгүй үзүүлбэл:

	Групп компани шийдвэрийн төрөл	Баталсан тогтоолын тоо
1	АПУ ХК ТУЗ-ийн хурлын тогтоол	25
2	АПУ Дэйри ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	6
3	АПУ Трейдинг ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	4
4	М Би Си Азиа Пасифик ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	4
5	СББ Трейд ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	4
6	Спирт бал бурам ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	4
7	ОХУ-ын Гранд ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	2
8	ОХУ-ын Гранд Ист ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	1
9	БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эйпиюү трейд ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	2
	Нийт	52

➤ **ТУЗ-ийн дэргэдэх хороод**

Компанийн тухай хуулийн 81.2-т заасны дагуу ТУЗ-ийн дэргэд Аудитын, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо ажилладаг бөгөөд хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн юм.

➤ **НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО**

Бүрэлдэхүүн	ТУЗ-ийн гишүүний хэлбэр	Нэрс
Хорооны дарга	Хараат бус гишүүн	О.Одбаяр
Гишүүд	Ердийн гишүүн	П.Батсайхан
	Хараат бус гишүүн	Ё.Гэрэлчулуун

Тайлант хугацаанд ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүнд дараах өөрчлөлт оров:

1. “ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга нь ТУЗ-ийн дарга бус, хараат бус гишүүн байна” гэсэн Кодексийн шаардлагыг хэрэгжүүлж, ТУЗ-ийн 2022.05.06-ны өдрийн 22/06 тоот тогтоолоор Нэр дэвшүүлэх хорооны даргаар ТУЗ-ийн дарга П.Батсайханы оронд ТУЗ-ийн хараат бус гишүүн О.Одбаярыг томиллов.

Компанийн дүрэмд заасан чиг үүрэг:

- ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
- ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүний хувьд Компанийн тухай хуулийн 79.1-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;
- ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;
- ТУЗ-ийн гишүүнээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах

Нэр дэвшүүлэх хороо 1 удаа 100%-ийн ирцтэйгээр хуралдаж, 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг нэр дэвшүүлэх шийдвэр гаргав.

ТУЗ-ийн дэргэдэх хороод Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, хороодын дүрэмд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллав.

Залгамж халааны бодлого

Залгамж халааны бодлого нь Компанийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, удирдах гол албан тушаалтны орон тоо суларснаас үүдэн хөрөнгө оруулагчид, оролцогч талууд хохирохгүй байх нөхцөлийг хангахын тулд ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийн залгамж халааг бэлтгэн, төлөвлөхөд чиглэгдэнэ.

Компанийн залгамж халааны бодлогод ТУЗ-ийн гишүүд, удирдах гол албан тушаалтан (Гүйцэтгэх захирал, Санхүү эрхэлсэн захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, бусад)-ы залгамж халааг Нэр дэвшүүлэх хороо төлөвлөн, нэр дэвшүүлэхээр заасан. Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийн залгамж халааг Гүйцэтгэх захирал Нэр дэвшүүлэх хороо болон Хүний нөөцийн чиг үүрэг эрхэлсэн захирлын хамт төлөвлөн, томилохоор заасан.

Залгамж халааны бодлогыг Кодексийн зарчимд нийцүүлэн шинэчлэн боловсруулах ажлыг 2022 онд хийж гүйцэтгэв.

➤ **ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО**

Бүрэлдэхүүн	ТУЗ-ийн гишүүний хэлбэр	Нэрс
Хорооны дарга	Хараат бус гишүүн	Ё.Гэрэлчулуун
Гишүүд	Ердийн гишүүн	Ж.Үнэнбат
	Хараат бус гишүүн	Кеннет Чу

Тайлант хугацаанд ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй.

Компанийн дүрэмд заасан чиг үүрэг:

- Компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
- ТУЗ болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;
- Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх

Цалин урамшууллын хороо 1 удаа 100%-ийн ирцтэйгээр хуралдаж, ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэх асуудлаар санал гаргаж ТУЗ-өөр батлуулав.

Цалин урамшууллын бодлого

Цалин урамшууллын бодлого нь Компанийн хэмжээнд баримтлах цалин хөлс, урамшууллын зарчмыг тодорхойлж, ТУЗ, Гүйцэтгэх удирдлага, Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд, нийт ажилтнуудын цалин хөлс, урамшууллын тогтолцооны үндснийг тогтооход чиглэгдэнэ.

Компани нь өөрийн цалин урамшууллын тогтолцоонд дараах суурь зарчмыг баримтална. Үүнд:

- Бизнесийн стратегитай уялдуулах,
- Өрсөлдөхүйц байх,
- Гүйцэтгэлд суурилах,
- Хүний хөгжилд анхаарах.

ТУЗ-ийн цалин урамшуулал: ТУЗ-ийн гишүүн нь тогтмол үндсэн цалин хөлстэй байх ба нэмэгдэл цалин, урамшууллыг ТУЗ-ийн шийдвэрээр олгож болно. ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх системийг Нэр дэвшүүлэх хороо болон/эсхүл Цалин урамшууллын хороо боловсруулж, мөрдөнө. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, ТУЗ-ийн ажлын албаны ажилтнуудын цалинг ТУЗ тогтооно.

Гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулал: Гүйцэтгэх удирдлага, Удирдлагын багийн гишүүдийн цалин хөлсний бүрдэл нь үндсэн цалин болон урамшууллаас бүрдсэн байна. Гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх, урамшуулал олгох, цалинг шинэчлэн тогтоох системийг Нэр дэвшүүлэх хороо болон/эсхүл Цалин урамшууллын хороо боловсруулж, мөрдөнө. Удирдлагын багийн гишүүдийн ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэн, урамшуулал олгох, цалинг шинэчлэн тогтоох шийдвэрийг Гүйцэтгэх удирдлага гаргана.

Компанийн ажилтны цалин урамшуулал: Нийт ажилтны цалин урамшууллыг Гүйцэтгэх удирдлага тогтооно. Тухайн жилийн батлагдсан бизнес төлөвлөгөөний хүрээнд Гүйцэтгэх удирдлагаас цалин хөлс, урамшууллыг шинэчлэн тогтоож болно.

Цалин урамшууллын бодлогыг Кодексийн зарчимд нийцүүлэн шинэчлэн боловсруулах ажлыг 2022 онд хийж гүйцэтгэв.

➤ **АУДИТЫН ХОРОО**

Бүрэлдэхүүн	ТУЗ-ийн гишүүний хэлбэр	Нэрс
Хорооны дарга	Хараат бус гишүүн	Ж.Үнэнбат
Гишүүд	Ердийн гишүүн	Сэн И-Ин
	Хараат бус гишүүн	О.Одбаяр

Тайлант хугацаанд ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй.

Компанийн дүрэмд заасан чиг үүрэг:

- Санхүүгийн тайлан санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавих,
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогод хяналт тавих, зөвлөх,
- Хяналтын болон эрсдэлийн удирдлагын бодлогод хяналт тавих, зөвлөх,
- Компанийн дотоод аудитын нэгжийн удирдлага, ажилтныг томилох санал боловсруулах, тэдгээрийн цалин урамшууллын хэмжээг тогтоох санал боловсруулах,
- Аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал өгөх,
- Их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах,
- ТУЗ-өөс даалгасны дагуу тодорхой асуудлаар хяналт шалгалт хийх, дүгнэлт гаргах

Дээрх чиг үүргийн дагуу Аудитын хороо нь 3 удаа, тус бүр 100%-ийн ирцтэйгээр хуралдаж, дараах асуудлаар санал, зөвлөмж, шийдвэр гаргаж ТУЗ-д танилцуулж, батлууллаа. Үүнд:

1. Групп компанийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын байгууллагын дүгнэлттэй танилцах,
2. Групп компанийн хэмжээнд 2022 оны санхүүгийн тайланд хийх аудитын байгууллага болон аудитын ажлын хөлсний хэмжээг санал болгох,
3. Дотоод аудитын нэгжийн удирдлагыг томилох санал гаргах.

Дотоод аудит

Дотоод аудитын бодлого


Дотоод аудит нь Компанийн үйл ажиллагааг үнэлэх, сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бие даасан, бодитойгоор баталгаа өгөх зөвлөх үйл ажиллагаа юм.

Компани бүхий л түвшинд эрсдэлд суурилсан дотоод аудитыг дараах чиглэлээр явуулдаг. Үүнд:

- Компанийн засаглалын үйл явцыг үнэлэх, сайжруулах зөвлөмж өгөх,
- Эрсдэлийн удирдлагын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлэх, сайжруулах,
- Дотоод хяналтын системийн үр нөлөөтэй, үр ашигтай байдалд үнэлгээ хийх, тэдгээрийн байнгын сайжруулалтад дэмжлэг үзүүлэх,
- Санхүүгийн үйл ажиллагаа болон тогтолцооны зөв найдвартай ажиллагааг үнэлэх, сайжруулах зөвлөмж өгөх.

Дотоод аудитыг гүйцэтгэхэд шударга байх, бодитой байх, нууц хадгалах, ур чадвартай байх зарчмыг баримталдаг.

Дотоод аудитын бодлогыг Кодексийн зарчимд нийцүүлэн шинэчлэн боловсруулах ажлыг 2022 онд хийж гүйцэтгэв.



Бүтцэд гарсан өөрчлөлт: ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны саналд үндэслэн ТУЗ-ийн 2022.12.07-ны өдрийн 22/22 тоот тогтоолоор Аудитын хороонд тайлагнах чиг үүрэг бүхий дотоод аудитын нэгжийн даргыг томилов.

Дотоод аудитын үйл ажиллагаа тайлант хугацаанд санхүүгийн болон үйл ажиллагааны нийцлийн аудитад түлхүү анхаарч ажиллав.

➤ **Эрсдэлийн удирдлага**

Эрсдэлийн удирдлагын бодлого

Эрсдэлийн удирдлагын бодлогоор эрсдэл гэдэгт компани зорилго, зорилтдоо хүрэхэд учрах тодорхой бус байдал, үр дагавар, гарз хохирлыг ойлгоно.

Эрсдэлийн эх үүсвэрээс нь хамааруулан стратегийн, санхүүгийн, үйл ажиллагааны, комплайнсын эрсдэл, үр дагавраас нь хамааруулан стратегийн түвшний, бизнес процессын түвшний, функциональ нэгжүүд болон хувь хүний түвшний эрсдэл хэмээн ангилдаг.

Эрсдэлийн удирдлага гэдэг нь байгууллагын бүхий л үе шатанд эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, эрсдэлд тохирох хариу арга хэмжээ авах, мэдээлэх тасралтгүй үйл ажиллагаа юм.

Эрсдэлийг удирдлагыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримталдаг:

- Соёлыг түгээх,
- Үнэ цэнийг бүтээх,
- Шийдвэр гаргалтад ашиглагдах
- Мэдээлэлтэй, ил тод байх,
- Чиг үүргийн хуваарилалт хийх,
- Тасралтгүй байх.

2022 онд шинэчлэгдэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хөтөлбөрийг АПУ компанид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу бид “Эрсдэлийн удирдлагын бодлого”-оо шинэчлэн батлуулахаар бэлтгэж буй бөгөөд үүний хүрээнд Дотоод хяналт, Дотоод аудитын үйл ажиллагаатай Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг уялдуулан, улам бүр сайжруулахыг зорьж ажиллаж байна.

Гэхдээ Геополитикийн хурцадмал байдал үргэлжилсэн хэвээр байгаа өнөө үед олон улсын нийлүүлэлтийн гинжин хэлхээний тасалдалтай холбоотой санхүүгийн зах зээлийн хямрал, инфляцын дарамт, валютын ханшийн өндөр хэлбэлзэл, төлбөр тооцоо шилжүүлгийн удаашрал зэрэг нь эдийн засагт хүчтэй нөлөө үзүүлэх замаар компанийн үйлдвэрлэл үйл ажиллагаанд томоохон сорилтуудыг дагуулсаар байна. Тийм хэдий ч олон улсын дипломат харилцаа

сайжирсан, урд хөршийн хил нээгдсэн зэрэг үйл явдлууд нь Монгол улсын гадаад худалдааны тэнцэл эерэг гарах, экспортын гол бүтээгдэхүүний гарц нэмэгдэх, үүнийгээ дагаад бизнесийн орчин сэргэх зэрэг эерэг төсөөллийг авч ирээд буй. Иймд АПУ ХК нь эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх замаар аливаа тодорхойгүй нөхцөл байдлыг тооцоотой төлөвлөгөө, хурдтай шийдвэр гаргалтаар даван туулах, санхүү, зардлын ухаалаг хэмнэлтийг тогтвортой хэрэгжүүлэх, шингэн хүнсний зүй зохистой хэрэглээг сурталчлан таниулах, багц бүтээгдэхүүний оновчлолыг сайжруулж, үйлдвэрлэлийн тасалдлаас урьдчилан сэргийлэх, экспортын зах зээлээ тэлэх чиглэлд төвлөрөн ажилласаар байна.

Мөн АПУ ХК-ийн тэргүүлэх тогтвортой хөгжлийн тэргүүлэх зорилт болон нийгмийн хариуцлагын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах “Чи Чадна- Шилээ дахин амьдрүүлъя” төсөл болон нийгэмдээ эерэг өөрчлөлт бий болгох зорилготойгоор “Соёлоор Гоёно” төслийг 2021 оноос эхлүүлэн хэрэгжүүлсээр байна.

Бид АПУ групп компанийн хэмжээнд эрсдэлийн соёлыг түгээн дэлгэрүүлэх, удирдлагыг шаардлагатай мэдээ, тайлангаар шуурхай хангаж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн олон төсөл хөтөлбөрүүдийг санаачлан, хэрэгжүүлсэн. Мөн бусад алба нэгжүүдийн оролцоотойгоор эрсдэлийг тодорхойлох, нарийвчилсан судалгаа анализ хийх, эрсдэлийг оновчтой үнэлж, зэрэглэх, эрсдэлийн стратегийн дагуу гүйцэтгэлийн мөшгөлт хийх зэрэг цогц үйл ажиллагааг өөрсдийн хэрэгжүүлсэн дотоодын эрсдэлийн удирдлагын программын тусламжтайгаар тогтмол хийж хэвшүүлсэн ба программын хэрэглээг нэмэгдүүлж, тасралтгүй сайжруулалтыг ханган ажиллаж байна.


➤ **Гадаад хүчин зүйлсийн нөлөөлөл, түүнд авч буй хариу арга хэмжээ**

Дэлхийн хэмжээнд

- САНКЦ, БОЙКОТ, ХЯЗГААРЛАЛТУУДАД МОНГОЛ УЛС ӨРТӨХ
- ЭДИЙН ЗАСГИЙН УНАЛТ
Өр, хүүгийн дарамт
Инфляцын дарамт
Валютын ханшийн хэлбэлзэл
Хөрөнгө оруулалт хумигдах
- БАЙГАЛИЙН ГАМШИГ, ЦАГ УУРЫН ӨӨРЧЛӨЛТҮҮД
Бараа таваарын үнийн өсөлт, шок
Байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр ТЭМ тасалдах
- ХҮНИЙ НӨӨЦ, НИЙГМИЙН ХЯМРАЛ
Халдварт өвчний тархалт
Ажиллах хүчний дутагдал
Нийгмийн сөрөг хандлага
Хэрэглэгчийн худалдан авах чадварын бууралт
- КИБЕР ЭРСДЭЛ
Кибер халдлагууд

Компанийн хэмжээнд

- ӨРТӨГ ЗАРДЛЫН ӨСӨЛТ
- НИЙЛҮҮЛЭЛТ ТЭМ ТАСАЛДАЛ
- ХҮНИЙ НӨӨЦ, АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДУТАГДАЛ
- НИЙГМИЙН ЭМЗЭГ БАЙДАЛ, СӨРӨГ ХАНДЛАГА
- КИБЕР ХАЛДЛАГА



● Эдийн засаг/Санхүү ● Байгаль орчин ● Нийгэм ● Дотоод ● Геополитик

ТОП ЭРСДЭЛҮҮД	ЮУ ТОХИОЛДОЖ БОЛОХ ВЭ?	ЭРСДЭЛИЙГ УДИРДАХЫН ТУЛД БИД ЮУ ХИЙЖ БАЙНА ВЭ?
<p>ӨРТӨГ ЗАРДЛЫН ӨСӨЛТ</p>	<p>Орос Украины үргэлжилсэн зөрчилдөөнт байдлаас үүдэлтэй гол бараа таваарын нийлүүлэлтийн саатал, тээвэр логистикийн асуудал нь үнийн хөөргөдлийг бий болгож, улмаар бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өртгийг нэмэгдүүлэн хүлээгдэж буй ашиг орлогын өсөлтийг сааруулахаар байна. Мөн инфляцтай холбоотойгоор амьжиргааны зардал өсөж хэрэглэгчийн худалдан авах чадварт сөргөөр нөлөөлөн бүтээгдэхүүний үнийн бодлогыг харилцан зохист түвшинд барихад хүндрэл үүсгэх эрсдэлтэй.</p>	<p>Энэ чиглэлд эрсдэлийг бууруулах/ сулруулах стратегийг баримталж байгаа ба брэнд портфолио менежментийг оновчлох, санхүүгийн сахилга баттай, ухаалаг зардлын хэмнэлтийг хэрэгжүүлэх, компанийн хэмжээнд зардлын хэмнэлтийн санал санаачилгыг тогтмол хүлээн авч, бодитоор хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>
<p>НИЙЛҮҮЛЭЛТ ТЭМ ТАСАЛДАЛ</p>	<p>Геополитикийн асуудлаас улбаатай тээвэр логистикийн саатал, хил гаалийн хязгаарлалтууд үүсэж, үүний улмаас компанийн ТЭМ цаг хугацаанд ирэхгүй байх, бэлтгэн нийлүүлэгчтэй хийх гэрээ, төлбөр тооцоо шилжүүлэг хойшлох, агуулахын зай талбай ашиглалтын ачааллыг нэмэх зэрэг борлуулалт, үйлдвэр төлөвлөлтөд томоохон сорилтыг бий болгож байна.</p>	<p>Энэ төрлийн эрсдэлээс зайлсхийхийн тулд гэнэтийн ямар ч өөрчлөлтөд бэлэн, уян хатан менежменттэй байх түүнтэй уялдсан бүтэцтэй болох, Бизнесийн тогтвортой үйл ажиллагааны төлөвлөгөөг баримтлан үйлдвэр төлөвлөлтийн цогц үйл ажиллагааг оновчлох ажлуудыг хийж байна.</p>
<p>ХҮНИЙ НӨӨЦ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДУТАГДАЛ</p>	<p>Дэлхий дахинд тулгарсан цар тахал түүнээс үүдсэн сөрөг үр дагаврууд нь нийт ажиллах хүчний бие физиологийн болоод сэтгэл зүйн хямралуудыг дагуулж бүтээмж сулрах, ажлаас халшрах хам шинж илрэх, ажлаас гарах орох урсгал нэмэгдэх, мөн шинэ үеийн залуусын зан төлөвт уялдуулан удирдах болон хамтран ажиллах арга барилаа өөрчлөх шаардлага үүсэх зэрэг хүнтэй холбоотой эрсдэлүүдийг дагуулж үүнд ихээхэн анхаарлаа хандуулах шаардлага тулгарч байна.</p>	<p>Ажилтнуудын сэтгэл зүйн эрүүл мэндэд чиглэсэн олон төсөл хөтөлбөр, сургалт уулзалтуудыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд: “APU LIFE”, “GOOD PLACE TO WORK”. Мөн хүн төвтэй бодлогын хүрээнд сургалт хөгжлөөр тасралтгүй хангах зорилгоор сургалтын академиудыг үүсгэн байгуулсан.</p>
<p>НИЙГМИЙН ЭМЗЭГ БАЙДАЛ, СӨРӨГ ХАНДЛАГА</p>	<p>Ядуурал, гэмт хэрэг, хүчирхийлэл зэрэг нийгмийн томоохон асуудлуудыг хөндөхдөө компанийн үйл ажиллагаатай холбох байдлаар олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэр хүндэд шууд халдах, сөрөг мессежийг түгээх, нэр хүндэд томоохон нөлөөлөл үзүүлэх санаатай үйлдлүүд нэмэгдэх магадлал өндөр байна.</p>	<p>Хуулийн шинэчлэлтэй холбоотойгоор архи, согтууруулах ундааны спиртийн градусыг шат дараатай бууруулах арга хэмжээг авч ажиллахын зэрэгцээ соёлтой хэрэглээг таниулан сурталчлах олон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд чиглэн ажиллаж байна.</p>
<p>КИБЕР ЭРСДЭЛ</p>	<p>Техник технологийн хурдацтай өөрчлөлт, шинэчлэлт, цахим шилжилтүүд нь өдөр тутмын үйл ажиллагааг хөнгөвчилж, шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх олон давуу тал, боломжийг бий болгож байгаа хэдий ч кибер халдлагууд болох phishing, scareware, Scam зэрэг сэжигтэй имейл ирэх залиланд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.</p>	<p>Компанийн хэмжээнд ISO27001:2013 Мэдээллийн системийн чанарын тогтолцоог нэвтрүүлэхээр бэлтгэж байгаа ба нийт ажилтнуудыг сэрэмжтэй байх тал дээр сургалт, мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна.</p>

➤ **ТУЗ-ийн цалин, урамшуулал**

ТУЗ-ийн дарга болон гишүүдэд сар бүр тогтмол цалин олгодог ба нэмэлт урамшуулал олгодоггүй. ТУЗ-ийн үндсэн цалингийн хэмжээнд ТУЗ-ийн 2022.05.06-ны өдрийн 22/07 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан.

ТУЗ-ийн гишүүдэд 2022 онд олгосон цалин, урамшуулал

ТУЗ-ийн гишүүн	Сарын үндсэн цалин (төг)		Олговол зохих нийт цалин (төг)	НДШ, ХХОАТ суутгал (төг)	Гарт олгосон нийт цалин
	1 – 4-р сар	5 – 12-р сар			
1 П.Батсайхан	6,000,000	10,000,000	104,000,000	15,525,680	88,474,320
2 Б.Батбаяр	4,500,000	6,500,000	70,000,000	12,125,680	57,874,320
3 Сергей Громов	4,500,000	6,500,000	70,000,000	12,125,680	57,874,320
4 Кеннет Чу	4,500,000	6,500,000	70,000,000	19,796,000	50,204,000
5 Сэн И-Ин	4,500,000	6,500,000	70,000,000	19,796,000	50,204,000
6 Том Холланд	4,500,000	-	18,000,000	5,532,000	12,468,000
7 Д.Миеэгомбо	-	6,500,000	52,000,000	8,617,120	43,382,880
8 Ё.Гэрэлчулуун	4,500,000	6,500,000	70,000,000	11,218,480	58,781,520
9 Ж.Үнэнбат	4,500,000	6,500,000	70,000,000	12,125,680	57,874,320
10 О.Одбаяр	4,500,000	6,500,000	70,000,000	12,125,680	57,874,320
НИЙТ	42,000,000	62,000,000	664,000,000	128,988,000	535,012,000

Дээр зааснаар тайлант оноос эхлэн Кодексийн шаардлагын дагуу ТУЗ-ийн цалингийн мэдээллийг нээлттэй, ил тод танилцуулж эхлэв.

➤ **Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал**

Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал (хувь хүн) хэрэгжүүлдэг. Гүйцэтгэх захирлыг сонгох, чөлөөлөх, бүрэн эрхийг тогтоох, түүнтэй байгуулах гэрээний нөхцөл, цалин, шагнал урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох нь ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарна.

Гүйцэтгэх захирлын цалин, урамшуулал нь ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан үндсэн цалин болон богино хугацааны урамшууллаас бүрдэнэ. Тайлант онд Гүйцэтгэх захирлын үндсэн цалинд өөрчлөлт ороогүй. Дараах гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу урамшуулал олгодог. Үүнд:

АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал нь Компанийн охин компаниуд болох АПУ ХК, АПУ Трейдинг ХХК, М Би Си Азия Пасифик ХХК, СББ Трейд ХХК, Спирт бал бурам ХХК, ӨМӨЗО-ны Эйпиюү Трейд ХХК-ын Гүйцэтгэх захирлаар давхар томилогдон ажилладаг.

Компанийн зорилт	Хэмжүүр	Зорилт	Эзлэх жин
Борлуулалтын орлого	Тухайн оны бизнес төлөвлөгөөтэй харьцуулснаар хэмжигдэнэ.	100%	25%
Хүү, татварын өмнөх ашиг	Тухайн оны бизнес төлөвлөгөөтэй харьцуулснаар хэмжигдэнэ.	100%	25%
Зардлын хэмнэлт	Нийт зардал хэмнэсэн байдлаар (тухайн оны төсвийн хэмнэлт болон FORCE төслийн хэмнэлт)	100%	25%
Хүн ба байгууллагын хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэл болон байгууллагын соёлыг сайжруулах ажлуудын үр дүн	80% нь хүн ба байгууллагын хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлээс хэмжигдэнэ. Үүнд: - Гол ажилтнуудыг тодорхойлох, залгамж халааны бодлого, процессын ажлууд - Гүйцэтгэлийн системийн хэрэгжүүлэлт, гүйцэтгэлийн үнэлгээ - Сургалт хөгжлийн бодлогод холбогдох ажлуудын хэрэгжилт - Гол ажлын байруудад чадвартай ажиллах хүчнийг ажиллуулах, чадавхжуулах 20% нь Байгууллагын соёлын судалгааны үр дүнгийн дагуу сайжруулах ажлын төлөвлөгөө ба судалгааны дүн өссөн байдлаар хэмжигдэнэ.	100%	25%

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

АПУ ХК-ийн гаргасан нийт хувьцаа **1,064,181,553**
 Халаасны хувьцаа **1,206,810**
 Эргэлтэд буй хувьцаа **1,062,974,743**

Компанийн зах зээлийн үнэлгээ 2022 оны эцэст 1 их наяд 585 тэрбум төгрөгт хүрснээр зах зээлийн үнэлгээгээр тэргүүлэгч компанийн байр сууриа хэвээр хадгаллаа. АПУ ХК нь МХБ-ийн зах зээлийн үнэлгээний 23%-ийг дангаар бүрдүүлэв.

Тайлант хугацаанд Компанийн 43.8 сая ширхэг үнэт цаас нийт 64.2 тэрбум төгрөгөөр арилжигдаж, үнийн дүнгийн эрэмбээр нэгдүгээрт, тоо хэмжээний эрэмбээр мөн нэгдүгээрт жагсжээ.

Хувьцааны хаалтын ханш:

- дунджаар 1,453 төг,
- хамгийн ихдээ 1,904 төг (2022.01.06-ны өдөр),
- хамгийн багадаа 1,225 төг (2022.06.17-ны өдөр) байв.



НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

Ногдол ашгийн журам

Ногдол ашгийн журмын дагуу Компани нь хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулж, ногдол ашгийн хэмжээг зохистой түвшинд байлгах бодлого баримталдаг.

Компани дор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна. Үүнд:

- Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх,
- Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх,
- Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.

Ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг ТУЗ гаргах ба санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор, хагас жилээр ногдол ашиг хуваарилах тохиолдолд хагас жилийн санхүүгийн тайлан гарснаас хойш 30 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

ТУЗ нь ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэвэл энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн хуралд заавалтайлагнана. Ногдолашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол шийдвэртээ хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр, ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана. Ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон тооцооллыг ТУЗ гаргах ба Гүйцэтгэх удирдлагаас санал болгож болно. Ногдол ашиг төлөх өдрийг Компанийн батлагдсан бизнес төлөвлөгөөтэй уялдуулж, боломжит хугацааг харгалзан тогтооно.

Ногдол ашиг хуваарилалт

Компанийн ногдол ашиг төлөлтийн харьцааг сүүлийн таван жилээр дараах хүснэгтэд үзүүлэв.



ТУЗ-өөс 2022 онд Компанийн хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд эхний хагас жилд 45 төгрөг, сүүлийн хагас жилд 44 төг, нийлбэр дүнгээр 89 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн болно.

Ногдол ашгийн хуваарилалт (сүүлийн 5 жил)

Тайлант хугацаа	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төг)	ТУЗ-өөс ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн өдөр	Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдөр
2018 он	46	2019.02.19	2019.04.04
2019 он	71	2020.02.14	2020.03.23
2020 он	95		
Үүнээс: I хагас жил	37.5	2020.08.13	2020.09.02
II хагас жил	57.5	2021.02.15	2021.03.31
2021 он	106		
Үүнээс: I хагас жил	46	2021.08.16	2021.09.03
II хагас жил	60	2022.02.17	2021.04.08
2022 он	89		
Үүнээс: I хагас жил	45	2022.08.03	2022.08.22
II хагас жил	44	2023.02.13	2023.04.07



Ногдол ашгийн төлбөрийг нийт хувьцааны таваас доош хувийг эзэмшигчдэд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар зуучлуулан, таваас дээш хувийг эзэмшигчдэд компаниас шууд төлөх замаар мөнгөн хэлбэрээр олгож байна.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ, ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тойм

Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “СЗХ” гэх)-ноос 2022.03.23-ны өдрийн 145 тоот тогтоолоор “Компанийн засаглалын кодекс” (цаашид “Кодекс гэх”)-ийг шинэчлэн баталсны дагуу Компанийн ТУЗ-өөс 2022.05.18-ны өдрийн №22/10 тоот тогтоолоор “Кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр”-ийг баталсан.

Тус хөтөлбөрийн хүрээнд компанийн засаглалын дараах 18 бодлого, дүрэм журам, зааврыг үе шаттайгаар Кодексийн зарчимд нийцүүлэн шинээр болон шинэчлэн батлах ажлыг төлөвлөн, хэрэгжүүлж байна. Үүнд:

Д/д	Баримт бичгийн нэр	Батлах хэлбэр	Хэрэгжилт
A	Дүрэм, бодлогын баримт бичиг, заавар болон бусад:		
1.	Бизнесийн ёс зүйн дүрэм	Шинээр баталсан	Хэрэгжсэн
2.	Залгамж халааны бодлого	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
3.	Цалин, урамшууллын бодлого	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
4.	Ногдол ашгийн бодлого	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
5.	Эрсдэлийн удирдлагын бодлого	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
6.	Дотоод аудитын бодлого	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
7.	Дотоод хяналтын бодлого	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
8.	Комплайнсын хяналтын бодлого/заавар	Шинээр батлах	Боловсруулж байна
9.	Тогтвортой хөгжлийн бодлого	Шинээр батлах	Боловсруулж байна
10.	Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого	Шинээр баталсан	Хэрэгжсэн
B	Дотоод журам:		
11.	Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
12.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
13.	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
14.	ТУЗ-ийн дэргэдэх хороод (Аудит, Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх)-ын журам	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
15.	Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны журам	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
16.	Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
17.	Дотоод хяналт, комплайнс, дотоод аудитын нэгж эсхүл ажилтны үйл ажиллагааны журам	Шинээр батлах	Боловсруулж байна
18.	Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам	Шинээр батлах	Боловсруулж байна

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээ

Монголын хөрөнгийн бирж (цаашид “МХБ” гэх)-ийн Гүйцэтгэх захирлын 2022.06.09-ний өдрийн А/58 тушаалаар баталсан аргачлалын дагуу Компаниас Кодексийн хэрэгжилтийн үнэлгээг анх 2022.06.16-ны өдөр хийж, МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлсэн.

Улмаар эхний үнэлгээнээс хойш 2022 оны үйл ажиллагааны тайлан бэлтгэх өдөр хүртэл хэрэгжүүлсэн ажлыг дүгнэн, 2023.04.01-ний өдрийн байдлаар өөрийн үнэлгээг давтан хийж, үнэлгээний нэгдсэн үр дүнг 2022.06 сарын үнэлгээтэй харьцуулсан байдлаар дор танилцуулав. Үнэлгээний асуулгын дагуух дэлгэрэнгүй тайлан МХБ-ийн цахим хуудсанд байршина.

АПУ ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ

Гарчиг	2022.06.16-ны өдрийн байдлаар			2023.04.01-ний өдрийн байдлаар			2022/2023 өсөлт
	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь	
1 ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	9	75%	12	12	100%	25%
2 ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	8	80%	10	9	90%	10%
3 Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%	6	6	100%	0%
4 Аудит, хяналтын тогтолцоо	6	5	83%	6	6	100%	17%
5 Эрсдэлийн удирдлага	8	6	75%	8	7	88%	13%
6 Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	3	50%	6	6	100%	50%
7 Оролцогч талуудын эрх ашиг	8	6	75%	8	8	100%	25%
8 Компанийн соёл	6	3	50%	6	6	100%	50%
9 Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	8	80%	10	8	80%	0%
Нэгдсэн дүн	72	54	75%	72	68	94%	19%

2. Дунд засаглалтай 1. Засаглал хэвийн буюу эрсдэлгүй 1 түвшин ахив.

Тайлбар:
 1. Нийт онооны 90% болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
 2. 70-89% байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
 3. 50-69% байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
 4. 49% болон түүнээс доош бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

АПУ ХК-ийн засаглалын нэгдсэн үнэлгээ 94% буюу “Засаглал хэвийн буюу эрсдэлгүй” түвшинд үнэлэгдлээ.

АПУ КОМПАНИЙН 2022 ОНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН АЖЛУУДЫГ ЗУРАГЛАХ НЬ

Бид тогтвортой хөгжих үндсээ бататгах хүрээнд 2022 онд байгаль орчин, нийгэм, засаглалын нөлөөллөө сайжруулах томоохон ажлуудыг эхлүүлж, урт хугацааны ач холбогдолтой ажлуудаа үргэлжлүүлэн гүйцэтгэлээ.

- Түүхий нүүрсний хэрэглээг үе шаттай халах, компаниас үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулах, эрчим хүч хэмнэх ажлыг үйлдвэрийн хэмжээнд уурын зуух төслөөр дамжуулан нэвтрүүлсэн.
- Хаягдлаа эргүүлэн авч, дахин амьдруулахаас гадна хог хаягдлын хэмжээгээ системтэйгээр бууруулах үйлсэд бид хүч түрэн ажилласан болно.
- Компанийн засаглалыг бэхжүүлэх зорилгоор бүх дүрэм, журмаа бид 2022 онд шинэчлэн батлах нүсэр ажлыг шуурхайлан гүйцэтгэж, хувьцаа эзэмшигчдээс гадна бүх оролцогч талуудын тэгш байдал, ашиг сонирхлыг хамгаалах сууриа бататгалаа.

- Хүртээмжтэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хариуцлагатай хэрэглээг сурталчлах, олон нийтийн эрүүл мэнд, чөлөөт цагийг спортоор дамжуулан дэвжээх ажлуудаа бид тасралтгүй урагшлуулсан. Компанийн дараагийн 100 жилийн тэргүүн чиг, нөлөөллийг тодорхойлох Тогтвортой хөгжлийн стратегиа бид 2023 онд батлуулахаар ажиллаж байгааг дуулгахад таатай байна. Ингэснээр Тогтвортой хөгжлийн 17 зорилгоос байгууллагын үйл ажиллагааны хүрээнд хамгийн өндөр бөгөөд бодит хувь нэмрийг оруулах боломж бийг мөн зураглаж, үе шаттайгаар төвлөрөн ажиллах юм.

Монгол улсын шингэн хүнсний манлай үйлдвэрлэгчийн хувьд эзлэх байр суурь, тэр чинээгээрээ хүлээж буй хариуцлагадаа бид эзэн болж, эргээд эх дэлхий, нийгэмдээ үзүүлж буй нөлөөллөө хүн төвт бодлоготойгоо уяж, ямар үйлсэд түлхэц болон ажиллаж байгааг та бүхэн тайлангаас хүлээн авна уу.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН



16 ЭНХ ТАЙВАН, ШУДАРГА ЁСЫГ ЦОГЦЛООХ

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС

Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх нь засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч, оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд тогтвортой үнэ цэнийг бүтээх ач холбогдолтой.

СЗХ-ноос Кодексийг шинэчлэн батлав.

2022.03.23

ТУЗ-өөс Кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг баталснаар засаглалын 18 бодлого, дүрэм, журмыг шинээр (6) болон шинэчлэн (12) боловсруулах ажил эхлэв.

2022.05.18

МХБ-ээс Кодексийн хэрэгжилтийг үнэлэх аргачлалыг батлав.

2022.06.09

Компаниас шинэчилсэн Кодексийн хэрэгжилтийг үнэлэх анхны өөрийн үнэлгээг хийв.

2022.06.16

Кодексийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд шинэчлэн батлах 12 бодлого, дүрэм, журам болон шинээр батлах 2 баримт бичиг ("Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого", "Бизнесийн ёс зүйн дүрэм")-ийг боловсруулж дуусган, батлуулахаар ТУЗ-д танилцуулав.

2022.12.31

Засаглалын тайлангийн дэлгэрэнгүйг "Компанийн засаглал" хэсгээс үзнэ үү.

13 УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨГ БАГАСГАХ



Байгаль орчны өдрүүд

АПУ ХК нь компанийн ажилтнууддаа зориулан "Дэлхийн Усны өдөр"-ийг тохиолдуулан "Өнгө нэм" ТББ -тай хамтран "Эх Дэлхийгээ Хайрлаж, Усаа хэмнэе!" өдөрлөгийг зохион байгуулсан. Өдөрлөгийн үеэр АПУ компани нь "Тогтвортой хөгжлийн зорилтууд"-д хүрэхийн төлөө цэвэр усны эх үүсвэрийг хайрлан хамгаалах, нөөцийг зүй зохистой ашиглах, хэмнэх, усыг дахин ашиглах үүднээс нэгж бүтээгдэхүүнд зарцуулагдах усны хэрэглээг бууруулахад чиглэсэн бодлогыг танилцуулж, сурталчиллаа.

Тэрбум мод

Нийслэлийн Байгаль Орчны газартай хамтран нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Нийслэлийн засаг даргын 2021 оны А/908 дугаар захирамжийн дагуу "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангуулж ажиллахаар нийслэлийн нутаг дэвсгэрт нэгдсэн зохион байгуулалтаар шилмүүст мод тарих ажилд АПУ ХК компани нь 1200 ширхэг шилмүүс нарс мод тарихаар Мөнхантайшир ХХК-тай хамтын ажиллагааг эхлүүллээ.

Түүхий нүүрсний хэрэглээг халж, бохирдлыг багасгах уурын зуухны төсөл

АПУ компанийн Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд нийгэм, байгаль орчиндоо ээлтэй "УУРЫН ЗУУХ"-ны төслийг АПУ ХК-ийн охин компани болох М-БИ-СИ АЗИА ПАСИФИК-ийн "Тайгер" шар айргийн үйлдвэрт амжилттай хэрэгжүүллээ.



Энэхүү төслийн хүрээнд хийгдсэн уурын зуух нь нийгэм, байгаль орчинд ээлтэй, агаарын бохирдол үүсгэхгүй, энергийн алдагдлыг бууруулан, жилд 3000тн түүхий нүүрсийг хэрэглээнээс халах боломжтой бөгөөд зуухны ашигт үйлийн коэффициент 95% болж нэмэгдсэн зэрэг олон давуу талтай юм.



6 БИЛЭГЭЭР ХАМГААХ
БАТАЛГААТ УНДНЫ УС, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖААР ХАНГАХ

Ус ашиглалт
Жил бүр усны хэрэглээг багасгах, хянах үүднээс “Ус ашиглалтын зардлын норм”-ыг шинэчлэн баталдаг. 2016 онд баталсан “Ус ашиглалтын зардлын норм”-ыг, БОНХАЖ сайдын 2015 оны А/301 тоот нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормтой харьцуулахад 1000 литр бүтээгдэхүүн тутамд 2.1-3.5 дахин бага ус зарцуулж байна.



СААРАЛ УС

Хаягдал усыг дахин ашиглах эх үүсвэр нь үйлдвэрийн тоног төхөөрөмжөөс хаягдаж байгаа ус тооцогдох ба үүнийг дахин ашиглаж Улаанбаатар хотын ногоон байгууламжийн усалгаа, угаалга, ариутгал хийхэд ашиглаж байна. Мөн үүнээс гадна үйлдвэр цехийн анхан шатны угаалга цэвэрлэгээ, үйлдвэрийн ариун цэврийн өрөөний суултуур зэрэгт ашиглаж байна. Усны шүүлтийн систем болон савлах үйлдвэрийн зайлсан усыг эргүүлэн ашиглах замаар нийт 13.123 м3 саарал усыг ашигласан байна.

7 ОРШООН АЖИЛЛАГА
СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧИЙГ НЭВТРҮҮЛЭХ

Цахилгаан, уур, усны хэрэглээ
Байгалийн нөөцийн хэмнэлтийн зорилгын хүрээнд дулаан, цахилгаан эрчим хүч, усны хэрэглээгээ зорилтот түвшнээс давуулан бууруулж өмнөх оны мөн үетэй харьцуулахад уурын хэрэглээг **1.7%**, цахилгааны хэрэглээг **3.5%**, усны хэрэглээг **5.3%** -иар тус тус бууруулсан байна.
Эрчим хүчний зарцуулалтыг бууруулах, дулааны алдагдлыг багасгах чиглэлээр тоног төхөөрөмж, техник, технологид томоохон хөрөнгө оруулалтыг хийсний дүнд **204.216 мян.кВт/цаг** цахилгаан эрчим хүч хэмнэж, нийт гэрлийн **95%**-ийг эрчим хүчний хэмнэлттэй LED технологид шилжүүлснээр гэрэлтүүлэгт зарцуулах эрчим хүчийг өмнөх оны мөн үеэс 10%-иар бууруулсан байна.

Аудит
АПУ ХК нь “Байгаль орчны аудит”-ын үнэлгээг 2022 оны 11-сарын 15 -аас 12 сарын 15-ны өдрийг хүртэл нийт 30 хоногийн хугацаанд байгаль орчны 7 бүрэлдэхүүн, 134 шалгуур үзүүлэлтээр үнэлүүлэн 95%-ийн гүйцэтгэлтэйгээр амжилттай хийлгэлээ.



10 ТӨРӨМӨЛӨГ
ТЭГШ БУС БАЙДЛЫГ БУУРУУЛАХ

Хүртээмжтэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжье
АПУ компани нь ажлын байрны хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллага”-аар шалгарлаа.
Бид хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүртээмжтэй ажлын байрыг бий болгох зорилтын хүрээнд:
1. Хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод дүрэм журам, нэрийн хуудсуудыг Брайл хэвлэлд хөрвүүлэн, дохионы хэлтэй сургалт видеог бэлтгэв.
2. JICA DPUB “Монгол улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх” төслийн хүрээнд Job Coach бэлтгэх сургалтад хамрагдав. Хүний нөөцийн нөөцийн мэргэжилтнүүдийг мэргэшсэн дохионы хэлмэрчийн сургалтад хамруулав.
3. Явган хүний замын тэмдэглэгээ, автомашины зогсоол, шатаар зөөвөрлөгчийг байршуулан ажиллаж байна.



8 ТӨРӨМӨЛӨГ
ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ

Аюулгүй ажиллагаа
2022 онд аюулгүй ажиллагааны өндөр гүйцэтгэлтэй ажиллаж 200,000 хүн/цаг тутамд ноогдох ослын давтамжийг **0.1** буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад **10%** бууруулж, нийт ажилтнуудад Хайнекен группийн шинэчлэгдсэн “Амь насаа хамгаалах 12 амлалт” дүрмийг таниулсан сургалтыг амжилттай зохион байгууллаа.



“Аюулгүй ажиллагааны манлайлагч” аян
Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор “Аюулгүй ажиллагааны манлайлагч” аяныг зохион байгууллаа. Аяны хүрээнд түгээлтийн тээврийн хэрэгслүүдийг хар хайрцаг, ухрах камер болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хэрэгслүүдийг бүрэн суурилуулж, учирч болох осол эндэгдлээс урьдчилан сэргийлж ажиллаа.




АПУ ХК Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу “Хан-Уул” дүүргийн хэмжээнд “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, сургуулилт”-д хамрагдан “Дүүрэн хангалттай” үнэлгээ авч тэргүүн байранд шалгарлаа.

ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ

“Монгол сарлаг” – гэр үйлдвэрлэлийн төсөл
 Сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь шингэн сүүний нийлүүлэлт, тээвэр логистикоос шууд хамааралтай бөгөөд малчин өрхийн амьжиргааг дэмжих анхан шатны боловсруулах үйлдвэрлэлийг бий болгоход чиглэн АПУ Дэйри Монгол сүүний үйлдвэр нь “МОНГОЛ САРЛАГ”- Гэр үйлдвэрлэлийн төслөө Архангай аймгийн Чулуут суманд 2022 онд эхлүүллээ. Төслийн хүрээнд Архангай аймгийн Чулуут сумын эхний 20 өрхтэй хамтын ажиллагааны гэрээг байгуулан малчдаас дээж бүтээгдэхүүнийг хуримтлуулж, туршилт судалгааг тасралтгүй явуулснаар түүхий эдийн татан авалт оновчтой болж, улирлын нөлөөлөл багасаж, малчин өрхийн орлого тогтмолжиж, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэхэд чухал нөлөөлөл үзүүлж буйг малчид онцолж байна. “МОНГОЛ САРЛАГ” - Гэр үйлдвэрлэлийн төсөл нь цагаан идээний уламжлалт үйлдвэрлэлд хүнсний эрүүл ахуйн стандарт бий болгон мөрдөхийн зэрэгцээ, хадгалалт, тээвэрлэлт, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, түгээлтийн нэгдсэн системийг бий болгож байна.



Сүү хүлээн авах жишиг цэг
 АПУ Дэйри Монгол сүүний үйлдвэр сүү хүлээн авах цэгийг боловсронгуй болгож, түүхий эдийн аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ малчдын амьжиргааг дэмжсэн жишиг сүү бэлтгэлийн хоршоог Төв аймгийн Батсүмбэр суманд байгуулсан. Энэхүү сүү хүлээн авах цэгт малчид шинэхэн сүүгээ стандартын шаардлага хангасан хөргүүртэй төхөөрөмжинд нийлүүлж, улмаар хэрэглэгчдэд хүнсний аюулгүй байдлыг хангасан цэвэр сүүг хүргэх нийлүүлэлтийг нэмэгдүүлсэн бөгөөд сүүний эргэлт сайжрах боломжийг бүрдүүлсэн юм..



“Хамтдаа – Сорилт, Гарц, Оролцоо” Харилцагчийн Нэгдсэн Чуулган
 АПУ ХК нь жил бүр харилцагчийн нэгдсэн чуулганыг уламжлал болгон зохион байгуулдаг бөгөөд 2022 онд “Үйлдвэрлэл, Худалдаа, Үйлчилгээ”-ний салбарын хамтрагч, харилцагч байгууллагуудтай хамтран зах зээлийн хүндрэлтэй нөхцөл байдалд хэрхэн хамтарч ажиллахаар хэлэлцэж, нээлттэй санал солилцох зорилгоор “Сорилт, Гарц, Оролцоо” сэдвийн дор харилцагчийн нэгдсэн чуулганаа зохион байгуулсан. Энэ үеэр бизнесийн орчны хүндрэлтэй нөхцөл байдал үүсэж, хил гааль, тээвэрлэлт, олон улсын геополитикийн асуудлуудаас үүдэлтэй түүхий эд, бараа материалын тасалдал бий болж, валютын ханшийн өсөлт тэргүүтэй хүчин зүйлсийн улмаас бараа, бүтээгдэхүүний үнэ огцом өсөхөд хүрээд байгааг бизнес эрхлэгчид онцолсон бөгөөд чуулганд ҮСХ-ны төлөөлөл оролцож, эдийн засгийн өөрчлөлт, түүхий эдийн тасалдал, инфляц, үнийн суурь хүчин зүйлсийн талаар бизнес эрхлэгчдэд мэдээлэл хүргэсэн юм.



12 ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ

"Spirit of Gobi 2022" Art and Music Festival

АПУ ХК-ийн нийгмийн эерэг өөрчлөлтийн "Соёлоор Гоёно" төсөл #SocialiseResponsibly уриатайгаар дэлхийд Монголыг сурталчлах зорилготой "Spirit of Gobi" Art and Music Festival-ыг 2022 онд амжилттай зохион байгуулсан. Энэ хүрээнд залуус, нийгэм, олон нийт, хэрэглэгчдийн дунд хэрэглээний соёлыг төлөвшүүлж, байгальд ээлтэй, хариуцлагатай, зөв зохистой хэрэглээг таниулах үүднээс "Spirit of Gobi" наадамд оролцсон бүх зочдодоо бид хаягдал шилээр бүтээл хийж, цагийг дурсамж дүүрэн өнгөрөөх боломжийг олгохоос гадна НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17 зорилтын нэг болох "Хариуцлагатай хэрэглээ"-ний ач холбогдлыг сурталчилсан юм.



"Гайхамшигт жолооч- Уусан бол жолоо барьдаггүй"

"АПУ" ХК нь нийгмийн манлайллын "Соёлоор гоёно" төслийн дэд хэсэг болгон хэрэгжүүлж байгаа билээ. Энэ хүрээнд компанийн тогтвортой хөгжлийн бодлогын нэг хэсэг болох "Хариуцлагатай хэрэглээ"-г бий болгох зорилгоор замын хөдөлгөөний аюулгүй байдал, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохын эсрэг "Гайхамшигт жолооч – Уусан бол жолоо барьдаггүй" хөтөлбөрийг хэрэгжүүлж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохын хор уршгийг нийгэмд таниулах, зөрчлөөс сэргийлэх арга зам, жолоодлогын үйлчилгээний талаарх мэдлэг, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр "АПУ" ХК, Тээврийн Цагдаагийн алба, "UB-Cab" байгууллагуудтай хамтран ажиллаж байна.



Энэхүү хөтөлбөр нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохын эсрэг олон улсын зан төлөвийн судалгаанд суурилан явагдаж байгаагаараа онцлог юм. Олон улсын судалгаагаар нийгмийн зан төлөвийн хувьд хэрэглэгч өөрийн жолоодлогын туршлага, арга барилыг сайн, хангалттай гэж үнэлсний улмаас согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох хандлага давамгайлдаг аж.



Уусан үедээ тээврийн хэрэгсэл барихгүй байх, жолооч дуудах арга хэрэгслийн талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байдаг тул богино хугацаанд зохисгүй шийдвэр гаргалт хийж согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож улмаар зөрчил үүсгэж, ноцтой хохирол учруулах эрсдэлийг үүсгэдэг байна. Иймд АПУ компани согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохын эсрэг нөлөөллийн хөтөлбөрийг ийнхүү эхлүүлж, нийгмийн эерэг нөлөөллийн төлөө олон талт хамтын ажиллагааг хэрэгжүүлсээр байна.



"Asia Summit Conference"

Дэлхийн 190 улсад үйл ажиллагаа явуулдаг Бүгд Найрамдах Итали Улсын CAMPARI групп компани нь 1860 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд АПУ компанитай 2016 оноос эхлэн хамтран ажиллаж байгаа билээ.

CAMPARI групп компаниас уламжлал болгон зохион байгуулдаг "Asia Summit Conference" арга хэмжээг амжилттай зохион байгуулсан бөгөөд нийт 16 улсаас "Best Creative Consumer Engagement" төрөлд АПУ ХК-ийн хэрэгжүүлсэн SKYY брэндийн нээлтийн үйл ажиллагаа шилдгийн шилдгээр шалгарж, зөв зохистой хариуцлагатай хэрэглээний соёлыг түгээн дэлгэрүүлж, олон улсын түвшинд ийнхүү сурталчиллаа.




ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ


“ЧИ ЧАДНА – ШИЛЭЭ ДАХИН АМЬДАРУУЛЪЯ ТӨСӨЛ”
 АПУ ХК нь 2022 онд “Шилээ дахин амьдруулъя” төслийн үргэлжлэл болгон шилний хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах хэрэглээний хэв маягийг бүрдүүлэх зорилгоор “Чи чадна” төслийг амжилттай хэрэгжүүллээ. Төслийн хүрээнд хэрэглэгч, түгээгч, тээвэрлэлтийн байгууллага болох бүхий л оролцогч талуудыг хамруулан шилийг онцгой үнээр эргүүлэн авч харилцан эдийн засгийн өгөөжийг хүртэх зарчмаар нийт 960 гаруй агентыг төсөлд нэгтгэж, шилний эргэлтийг 3 дахин нэмэгдүүлж чадлаа.




Шилээ дахин амьдруулснаар түүхий эд, орц найрлагад орох байгалийн нөөц баялгийг хэмнэх, шилний импортын хамаарлыг багасгаж, хил гаалийн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулах, шил шинээр үйлдвэрлэхээс гарах хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зэрэг нийгэм эдийн засаг, байгаль орчинд ихээхэн өндөр ач холбогдолтой юм. Бид шингэн хүнсний салбарт тэргүүлэгч компанийн хувьд үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн сүлжээндээ өөрсдийн бэлтгэн нийлүүлэгч, харилцагчдаа байгальд орчинд ээлтэй, хариуцлагатай байх чиглэлд хамтын бодлого баримтлан ийнхүү ажиллаж байна.



Хог хаягдлын менежмент
 АПУ ХК нь хог хаягдлын менежментийг үйлдвэрлэлээс гарч буй бүх төрлийн хатуу хог хаягдлын хүрээнд хэрэгжүүлдэг ба хог хаягдлын хэмжээг бууруулах, ландфиллд хаягдах хаягдлыг багасгах хүрээнд Шинэ Шил ХХК, Пластик сентер ХХК, Ногоон Ойм урлан ХХК зэрэг компаниудтай хамтран ажиллаа.



Энэ хүрээнд үйлдвэрлэлийн хог хаягдлын хэмжээг энэ үеийн өмнөх үетэй харьцуулахад 30% -аар бууруулж, хаягдал шилийг хөөсөн шил боловсруулах үйлдвэр Шинэ Шил ХХК-д, хаягдал гялгар уутыг Пластик сентер ХХК-д тус тус нийлүүлэн нүхэн жорлонгийн доторлогоо, барилгын дулаалгын хөөс хийхэд зориуллаа.



НҮҮРСХҮЧЛИЙН ХИЙ
 Шар айрагний исгэлтээс ялгарч байгаа нүүрсхүчлийн хийг агаарт буюу байгаль орчинд хаялгүй боловсруулж нийт **2.102.341кг нүүрсхүчлийн хийг** үйлдвэрлэлд дахин ашигласан.



Шингэн хаягдал
 Шингэн хаягдлын хувьд үйлдвэрээс органик түүхий эд болох улаан буудай, арвайн соёолж, хөрөнгийн үлдэгдэл, шар айраг шүүлтүүрийн материал кизельгур зэрэг гардаг ба дахин ашиглалтыг онцгой анхаарч ажиллаж байна.



Тухайлбал өмнө нь бид шар айргийн шүүлтийн процесст оролцдог Кизельгургыг хаягдал усны шугамд хаядаг байсан бол одоо шүүх хатаах төхөөрөмж суурилуулан хатуу хог хаягдал болгон ашиглаж байна. Кизельгур нь байгалийн нэгдэл бөгөөд агрохими хүнд металлын шинжилгээгээр стандартын шаардлага хангадаг учир газар тариалангийн салбар болон зам барилга салбарт ашиглах боломжтой гэдэг эрдэмтдийн судалгаан дээр үндэслэн судалгааны ажлыг “Ойм Ногоон урлан ХХК”-тай хамтран эхлүүлсэн. Үйлдвэрлэлээс гарч буй нийт хог хаягдлыг 9.8 хувийг эзэлдэг кизельгурийн эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг бид ийнхүү судалж байна. Үүний хамгийн том ач холбогдол нь хөрсний доройтол, цөлжилтийг бууруулахаас гадна төвлөрсөн хогийн цэгт очих хаягдлыг бууруулах үр нөлөөтэй юм.

Хаягдал шил
 Бид хаягдал шилээ дахин ашиглах зорилгоор Шинэ Шил ХХК-тай хамтран ажиллах гэрээний дагуу одоогийн байдлаар 400 орчим тонн шилийг нийлүүлсээр байна. Хөөсөн шил үйлдвэрлэх туршилтыг анхлан явуулахад АПУ компаниас гарч байгаа хаягдал шилний цахиур түүхий эдийн шаардлагыг бүрэн хангаж байсан тул ийнхүү эдийн засгийн эргэлтэд оруулж эхэллээ. Хөөсөн шил нь импортыг орлох бүтээгдэхүүн бөгөөд галд тэсвэртэй, цантахгүй, бат бөх, амархан зүсэгддэг зэрэг олон давуу талтай.



12 ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ

СПОРТЫГ ДЭМЖИХ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Спорт бол бидний бахархал, эв нэгдэл, соёл, хамтдаа бүтээх гэрэлт ирээдүйн гүүр билээ.



➤ **FC ULAANBAATAR**
 АПУ ХК нь хөлбөмбөгийн спортын хөгжлийг дэмжих замаар залуучуудын эрүүл амьдралын хэв маяг, зөв дадал хэвшлийг бий болгох зорилгоор “ФС УЛААНБААТАР” хөлбөмбөгийн шигшээ багийг 8 дах жилдээ дэмжин, хамтран ажиллаж байна. 2022 оны хувьд “ФС УЛААНБААТАР” хөлбөмбөгийн багийн тамирчид болох Б.Балжинням, Э.Мөнх-Эрдэнэ, О.Оюунбаатар нар Монголын Хөл Бөмбөгийн Холбооны “Алтан бөмбөг 2022” наадмын “ШИЛДЭГ ЭРЭГТЭЙ ТОГЛОГЧ”-оор тодорсон бөгөөд АПУ ХК-ийн хамтын ажиллагааны үр дүнд хөлбөмбөгийн тамирчдын чадвар, чансаа сайжирч, спортод хайртай залуусын сонирхол, хүсэл тэмүүллийг ийнхүү дэмжсээр байна. Соёлтой, хариуцлагатай, хүндлэл дүүрэн спортын ертөнцийг хамтдаа бүтээе.



➤ **ҮНДЭСНИЙ ДЭЭД ЛИГ**
 АПУ ХК нь залуучуудын эрүүл мэндийн зохистой дадал, хэвшлийг бий болгох зорилгоор сагсан бөмбөгийн спортын хөгжилд хувь нэмэр оруулан “Монголын Сагсан Бөмбөгийн Холбоо” /МСБХ/-ны Үндэсний дээд лигийг урт хугацаандаа дэмжин хамтран ажиллаж байна. Тухайлбал АПУ ХК-ийн Сэнгүр брэнд нь 2013 оноос Үндэсний Сагсан Бөмбөгийн Холбооноос зохион байгуулдаг Монголын хамгийн том, чансаа өндөртэй Супер Лиг болон Үндэсний 21 аймгийн лигийн ерөнхий ивээн тэтгэгчээр тасралтгүй 9 жил ажиллаж, спортод хайртай залуусын сонирхол, хүсэл тэмүүллийг ийнхүү дэмжсээр байна. Энэхүү спортын хамтын ажиллагааны үр дүнд спортын лигийн маркетинг, менежментийн үйл ажиллагааг цоо шинэ түвшинд хүрсэн бөгөөд АПУ ХК-ийн зүгээс ҮСБХ-той хамтран NBA-н медиа сувгийн гол контентууд болох TOP 10, Highlights, Shaqtin’ A fool зэргийг анхлан нэвтрүүлж, Лигийн нээлт, All Stars, Play Off, Final тоглолтуудыг мэргэжлийн өндөр түвшинд олон нийтэд хүргэж ажиллаж байна.



➤ **ОРГИЛУУН ЛИГ**
 Оргилуун брэндтэй ОРГИЛСОН их хүслээр нэгдсэн, сагсан бөмбөгт хайртай дуртай залуусыг АПУ ХК-ийн Оргилуун брэнд үргэлж дэмждэг. 2022 оны Монголын хамгийн олон сагсан бөмбөг сонирхогч залуус оролцсон Сонирхогчдын Сагсан Бөмбөгийн ОРГИЛУУН ЛИГ амжилттай зохион байгуулагдаж аваргуудаа тодруулсан бөгөөд нийт 56 багийн 1000 гаруй тамирчид, 100 гаруй дасгалжуулагчид оролцож, 5 сарын турш ширүүн өрсөлдөн АВАРГА багаар “ЗАВХАН ГАРДИ” баг шалгарч Дэд байрт “МУИС ШОНХОРУУД Hi-Pay Diamond” баг Гутгаар байрт “ЗАВХАН БРОДЕРС” баг тус тус шалгарсан юм. Тоглолтын шийдвэрлэх үе Аваргын төлөө тоглолтод “ЗАВХАН ГАРДИ” 77-76 “МУИС Шонхорууд” Цувралын гурав дахь тоглолтод “ЗАВХАН ГАРДИ” баг хожсоноор лигийн аваргаар тэд тодорсон юм.

ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

		Аудитлагдсан НСТ 2022	Аудитлагдсан НСТ 2021_ restated	Аудитлагдсан НСТ 2021
Борлуулалтын орлого (цэвэр)	сая.төг	850,240	678,164	678,164
Борлуулалтын өртөг	сая.төг	(478,213)	(343,230)	(343,230)
Нийт ашиг (алдагдал)	сая.төг	372,027	334,934	334,934
Борлуулалт, удирдлагын зардал	сая.төг	(201,932)	(138,348)	(138,283)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт	сая.төг	112	(302)	(302)
Бусад орлого	сая.төг	7,656	3,761	3,761
Бусад зардал	сая.төг	(13,410)	(2,217)	(2,217)
Үйл ажиллагааны ашиг	сая.төг	164,452	197,828	197,893
Санхүүгийн орлого	сая.төг	151	520	520
Санхүүгийн зардал	сая.төг	(10,491)	(3,653)	(3,653)
Татварын өмнөх ашиг	сая.төг	154,112	194,695	194,759
Орлогын албан татварын зардал	сая.төг	(28,215)	(41,074)	(41,074)
Тайлант үеийн цэвэр ашиг	сая.төг	125,898	153,621	153,686
Бусад дэлгэрэнгүй орлого				
Ашиг, алдагдал руу дахин ангилагдахгүй зүйлс:				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	сая.төг	65,810	-	-
Ажилчдын тэтгэмжийн дахин хэмжилтийн алдагдал	сая.төг	(439)	(275)	(275)
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	сая.төг	747	(22)	(22)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	сая.төг	192,015	153,324	153,389
Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ноогдох	сая.төг	144,693	159,654	159,718
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ноогдох	сая.төг	(18,795)	(6,033)	(6,033)
Тайлант үеийн цэвэр ашиг	сая.төг	125,898	153,621	153,686
Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ноогдох	сая.төг	210,811	159,357	159,422
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ноогдох	сая.төг	(18,795)	(6,033)	(6,033)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлогын нийт дүн	сая.төг	192,015	153,324	153,389
Нэгж хувьцаанд ноогдох ашиг				
Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг /алдагдал/	сая.төг	136.1	150.2	150.3

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

		Аудитлагдсан НСТ 2022	Аудитлагдсан НСТ 2021_ restated	Аудитлагдсан НСТ 2021
Хөрөнгө				
Үндсэн хөрөнгө	сая.төг	415,600	282,878	283,565
Биет бус хөрөнгө ба гүүдвил	сая.төг	74,045	80,977	80,977
Хойшлогдсон татварын хөрөнгө	сая.төг	1,337	1,034	1,034
Эргэлтийн бус хөрөнгө	сая.төг	490,982	364,889	365,575
Бараа материал	сая.төг	185,883	87,714	87,714
Урьдчилгаа, урьдчилж төлсөн зардал	сая.төг	65,530	53,774	53,774
Орлогын албан татварын авлага	сая.төг	9,656	148	148
Дансны болон бусад авлага	сая.төг	51,008	32,723	32,723
Бусад санхүүгийн хөрөнгө оруулалт	сая.төг	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	сая.төг	38,365	77,278	77,278
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	сая.төг	709	-	-
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	351,152	251,637	251,637
Нийт хөрөнгө	сая.төг	842,134	616,525	617,212
Эздийн өмч				
Хувьцаат капитал	сая.төг	106	106	106
Нэмж төлөгдсөн капитал	сая.төг	338,095	338,095	338,095
Нэгдлийн нөөц	сая.төг	(112,796)	(112,796)	(112,796)
Дахин үнэлгээний нөөц	сая.төг	156,567	92,842	99,774
Гадаад валютын хөрвүүлгийн нөөц	сая.төг	704	(43)	(43)
Хуримтлагдсан ашиг	сая.төг	220,738	186,012	179,766
Хяналтын эрхгүй хувь оролцоо	сая.төг	30,163	84	84
Нийт эздийн өмч	сая.төг	633,577	504,300	504,987
Өр төлбөр				
Хойшлогдсон татварын өглөг	сая.төг	25,540	15,978	15,978
Урт хугацаат бусад өглөг	сая.төг	2,326	-	-
Урт хугацаат түрээсийн өглөг	сая.төг	31,334	13,134	13,134
Ажилтны тэтгэмж	сая.төг	1,381	817	817
Урт хугацааны зээл	сая.төг	18,333	21,115	21,115
Урт хугацаат өр төлбөр	сая.төг	78,913	51,045	51,045
Богино хугацаат түрээсийн өглөг	сая.төг	10,935	5,266	5,266
Орлогын албан татварын өглөг	сая.төг	191	8,146	8,146
Дансны өглөг	сая.төг	51,633	21,965	21,965
Бусад өглөг	сая.төг	61,718	25,804	25,804
Богино хугацаат зээл	сая.төг	5,167	-	-
Богино хугацаат өр төлбөр	сая.төг	129,644	61,181	61,181
Нийт өр төлбөр	сая.төг	208,557	112,226	112,226
Нийт өр төлбөр ба эздийн өмч	сая.төг	842,134	616,525	617,212

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

		Аудитлагдсан НСТ 2022	Аудитлагдсан НСТ 2021_ restated	Аудитлагдсан НСТ 2021
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
Тайлант жилийн ашиг	сая.төг	125,898	153,621	153,686
Тохируулга:	сая.төг	-	-	-
Орлогын албан татварын зардал	сая.төг	28,215	41,074	41,074
Зээлийн хүүгийн зардал	сая.төг	1,917	802	802
Түрээсийн хүүгийн зардал	сая.төг	4,729	2,092	2,092
Нөөцийн дискаунтын чөлөөлөлт	сая.төг	56	44	44
Хүүгийн орлого	сая.төг	(151)	(520)	(520)
Валютын ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй гарз/(олз), цэвэр	сая.төг	6,222	(154)	(154)
Элэгдлийн зардал	сая.төг	59,294	36,022	36,040
Хорогдуулгын зардал	сая.төг	7,466	7,381	7,381
Дансны болон бусад авлагын үнэ цэнийн бууралт, (цэвэр)	сая.төг	48	262	262
Банкны үлдэгдэл дэх үнэ цэнийн бууралт	сая.төг	(160)	40	40
Урьдчилж төлсөн төлбөрийн үнэ цэнийн бууралт	сая.төг	-	-	-
Бараа материалын үнэ цэнийн бууралт	сая.төг	22	180	180
Данснаас хассан бараа материал	сая.төг	-	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	сая.төг	(128)	(102)	(102)
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз	сая.төг	29	449	443
Хасагдсан үндсэн хөрөнгө	сая.төг	589	375	381
Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралт	сая.төг	8,358	-	-
Биет бус хөрөнгө борлуулсны гарз	сая.төг	-	-	-
	сая.төг	242,404	241,566	241,649
Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлт:				
Дансны авлага болон бусад авлага	сая.төг	(17,467)	6,028	6,028
Бараа материал	сая.төг	(97,862)	(4,560)	(4,560)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	сая.төг	(709)	-	-
Урьдчилгаа	сая.төг	(13,210)	(16,134)	(16,134)
Дансны өглөг	сая.төг	25,560	10,728	10,728
Бусад өглөг	сая.төг	25,273	(15,864)	(15,864)
Ажилтны тэтгэмж	сая.төг	69	(159)	(159)
	сая.төг	164,059	221,605	221,688

		Аудитлагдсан НСТ 2022	Аудитлагдсан НСТ 2021_ restated	Аудитлагдсан НСТ 2021
Зээлийн хүүний төлбөрт төлсөн	сая.төг	(579)	(802)	(802)
Түрээсийн хүүний төлбөрт төлсөн	сая.төг	(4,729)	(2,092)	(2,092)
Хүлээн авсан хүүгийн орлого	сая.төг	151	520	520
Төлсөн орлогын албан татвар	сая.төг	(46,257)	(37,667)	(37,667)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	112,646	181,564	181,647
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
Худалдаж авсан үндсэн хөрөнгө	сая.төг	(92,642)	(65,084)	(65,084)
Худалдаж авсан биет бус хөрөнгө	сая.төг	(547)	(1,052)	(1,052)
Худалдаж авсан хяналтын эрхгүй хувь оролцоо	сая.төг		-	
Борлуулсан үндсэн хөрөнгө	сая.төг	413	125	42
Бусад санхүүгийн хөрөнгө оруулалтыг олж эзэмшихэд төлсөн	сая.төг	-	-	-
Бусад санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсан	сая.төг	-	500	500
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(92,777)	(65,511)	(65,594)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
Зээлийн эргэн төлөлт	сая.төг	(45,500)	-	-
Төлсөн ногдол ашиг	сая.төг	(100,763)	(118,447)	(118,447)
Түрээсийн өглөгт төлсөн	сая.төг	(6,474)	(3,438)	(3,438)
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	сая.төг	25,098	-	-
Урт хугацааны зээл авсан	сая.төг	67,000	19,116	19,116
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(60,639)	(102,770)	(102,770)
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	сая.төг	309	(8)	(8)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт / (бууралт)	сая.төг	(40,461)	13,275	13,275
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	сая.төг	77,278	64,059	64,059
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийн бууралт	сая.төг	160	(40)	(40)
Мөнгөн хөрөнгө дэхь гадаад валютын ханшийн хэлбэлзлийн нөлөөлөл	сая.төг	1,388	(17)	(17)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	сая.төг	38,365	77,278	77,278

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Нэгдлийн нөөц	Дахин үнэлгээний нөөц	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн	Хяналтын эрхгүй хувь оролцоо	Нийт дүн	
2021 эхний үлдэгдэл / нэгтгэсэн/	сая.төг	106	338,095	(112,796)	100,178	(21)	129,937	455,499	6,117	461,616
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	сая.төг	-	-	-	(7,036)	-	6,413	(622)	-	(622)
2021 эхний үлдэгдэл / нэгтгэсэн/	сая.төг	106	338,095	(112,796)	93,142	(21)	136,351	454,877	6,117	460,993
Нийт дэлгэрэнгүй орлого	сая.төг	-	-	-	-	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	сая.төг	-	-	-	-	-	159,654	159,654	(6,033)	153,621
Бусад дэлгэрэнгүй орлого	сая.төг	-	-	-	-	(22)	(275)	(297)	-	(297)
Зарласан ногдол ашиг	сая.төг	-	-	-	-	-	(110,018)	(110,018)	-	(110,018)
Худалдаж авсан хяналтын эрхгүй хувьцаа	сая.төг	-	-	-	-	-	-	-	-	-
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн	сая.төг	-	-	-	(300)	-	300	-	-	-
2021 эцсийн үлдэгдэл / нэгтгэсэн/	сая.төг	106	338,095	(112,796)	92,842	(43)	186,012	504,216	84	504,300
Нийт дэлгэрэнгүй орлого	сая.төг	-	-	-	-	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	сая.төг	-	-	-	-	-	144,693	144,693	(18,795)	125,898
Бусад дэлгэрэнгүй орлого	сая.төг	-	-	-	65,810	747	(439)	66,118	-	66,118
Зарласан ногдол ашиг	сая.төг	-	-	-	-	-	(111,612)	(111,612)	-	(111,612)
Худалдаж авсан хяналтын эрхгүй хувьцаа	сая.төг	-	-	-	-	-	-	-	-	-
Нэмэгдүүлсэн хувьцаат капитал	сая.төг	-	-	-	-	-	-	-	48,874	48,874
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн	сая.төг	-	-	-	(2,085)	-	2,085	-	-	-
2022 эцсийн үлдэгдэл / нэгтгэсэн/	сая.төг	106	338,095	(112,796)	156,567	704	220,739	603,414	30,163	633,577

ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ

ТАЙЛАГНАЛЫН НИЙЦЭЛ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг Монгол улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актын хүрээнд бэлтгэсэн.

Уг тайланг Санхүүгийн тайлангийн Олон Улсын Стандарт (“СТОУС”) 10 буюу “Нэгтгэсэн санхүүгийн Тайлан” хэмээх стандартын арга аргачлалыг ашиглан бэлтгэсэн.

ҮНЭЛГЭЭНИЙ СУУРЬ

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулахдаа санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчимд үндэслэн бэлтгэсэн.

БҮРТГЭЛИЙН БОЛОН ТОЛИЛУУЛГЫН ВАЛЮТ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг компанийн бүртгэлийн валют болох Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр толилуулсан бөгөөд энэ нь компанийн үйл ажиллагаа явуулж буй анхдагч эдийн засгийн орчны үндсэн валют болно.

ТААМАГЛАЛ, ТООЦООЛОЛ БОЛОН ҮНЭЛЭМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг СТОУС болон НББОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, мөн хөрөнгө, өр төлбөр, орлого зардлын зүйлсийн дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно. Удирдлага эдгээр тооцоолол болон түүнд хэрэглэсэн таамаглалыг байнга хянаж байдаг.

ГАДААД ВАЛЮТААРХ АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн мөнгөн зүйлсийг балансын өдрийн хаалтын ханшаар төгрөг рүү хөрвүүлэн илэрхийлдэг.

Бодит үнэ цэнээр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийн зүйлсийг тухайн бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлдэг. Түүхэн өртгөөр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар тайлагнадаг.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ. Компани нь зээл болон авлагыг анх үүссэн тухай бүр нь хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн хөрөнгүүдийг (ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр тодорхойлогдсон хөрөнгүүдийг оролцуулаад) хэлцэл хийгдсэн өдөр буюу тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд компани гэрээний нэг тал болсон өдрөөр хүлээн зөвшөөрдөг.

АВЛАГА. Уг хөрөнгийг бодит үнэ цэнэ дээр тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан шууд зардлыг нэмсэн дүнгээр анх хүлээн зөвшөөрдөг.

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР. Компани нь гаргасан өрийн бичиг, өр төлбөрийг тухайн ажил гүйлгээг үүссэн өдрөөр хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн өр төлбөрийг (ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр тодорхойлогдсон хөрөнгүүдийг оролцуулаад) хэлцэл хийгдсэн өдөр буюу тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд компани гэрээний нэг тал болсон өдрөөр хүлээн зөвшөөрдөг.

САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨРИЙГ ЦЭВЭР ДҮНГЭЭР ТУСГАХ.

Компани хүлээн зөвшөөрөгдсөн дүнг хооронд нь хаах хууль эрх зүйн эрхтэй байх, мөн цэвэр дүнгээр нь төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах зорилготой үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг.

ҮНДСЭН ХӨРӨНГӨ

АНХДАГЧ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ.

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй үндсэн хөрөнгийн зүйлсийг анхны удаа өртгөөр нь хэмждэг. Өртөгт тухайн хөрөнгийг худалдан авахтай шууд холбогдон гарсан зардлууд багтдаг.

ДАРАА ҮЕИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ.

Барилга байгууламж, газар, тоног төхөөрөмжийн бүлэг үндсэн хөрөнгийг хөрөнгөөр хүлээн зөвшөөрсний дараа түүний бодит үнэ цэнийг илтгэх дахин үнэлсэн дүнгээр хэмжих ба дахин үнэлсэн дүн нь дараа үеийн хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байдаг. Хөрөнгийн бодит үнэ цэнийг Монгол Улсын хараат бус гуравдагч этгээд тогтоодог.

ДАРАА ҮЕИЙН ЗАРДАЛ.

Дараа үеийн зардлыг зөвхөн эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай гэдэг нь тогтоогдсон үед капиталжуулан бүртгэдэг. Урсгал засварын зардлыг гарсан тухайн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрдөг.

ЭЛЭГДЭЛ.

Үндсэн хөрөнгийн зүйлсийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн ашиглалтын жилээр тооцон шулуун шугамын аргаар элэгдүүлж, орлогын тайланд бүртгэдэг. Үндсэн хөрөнгийг түүнийг байршуулж, ашиглахад бэлэн болсон үеэс нь, дотооддоо барьж байгуулсан хөрөнгийн хувьд тэдгээрийг дуусгавар болгож, үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон үеэс нь эхлэн элэгдэл байгуулдаг.

БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Компани биет бус хөрөнгө худалдан авсан бөгөөд түүний ашиглалтын жилийг тодорхойлох боломжтой бол түүний өртгөөс хуримтлагдсан хорогдуулга болон үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ

Биологийн хөрөнгийг борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнээр нь хэмжих бөгөөд үүнтэй холбоотой үүсэх олз ба гарзыг тухайн тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

ЗЭЭЛИЙН ӨРТӨГ

Компани бэлтгэл шаардагдах хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай зээлийн өртгийг тухайн хөрөнгийн өртгийн хэсэг болгон капиталжуулдаг. Бусад зээлийн өртгийг гарсан тайлант үед нь зардлаар хүлээн зөвшөөрдөг.

БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнийн аль багаар үнэлдэг. Бараа материалын өртгийг дундаж өртгийн аргаар тодорхойлох бөгөөд бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбогдож гарсан бүх зардлууд ордог. Үйлдвэрийн бараа материал, дуусаагүй үйлдвэрлэлийн хувьд хэвийн хүчин чадлаар ажиллах үеийн үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын зохих хэсгийг өртөгт хуваарилдаг.

ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ.

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдээгүй санхүүгийн хөрөнгийн хувьд тэдгээрт үнэ цэнийн бууралт үүссэн гэдэг бодит нотолгоо байгаа эсэхийг тайлант хугацааны эцэс бүрт үнэлж тодорхойлдог.

ХОРОГДУУЛСАН ӨРТГӨӨР ИЛЭРХИЙЛСЭН САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ.

Компани эдгээр хөрөнгүүдийг тусад нь мөн хамтад нь үнэ цэнийн бууралтын нотолгоо байгаа эсэхийг үздэг. Бүх мэдэгдэхүйц хэмжээний хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тусад нь үнэлнэ.

САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ.

Тайлант үеийн эцэст бараа материал, хойшлогдсон татварын хөрөнгөөс бусад санхүүгийн бус хөрөнгийн дансны үнэнд үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлдэг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрсэн бол тухайн хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно.

АЖИЛЧДЫН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, УРАМШУУЛАЛ АЖИЛЧДЫН БОГИНО ХУГАЦААТ ТЭТГЭМЖ.

Холбогдох үйлчилгээ үзүүлсэн үед ажилчдын богино хугацаат тэтгэмжийг зардлаар бүртгэдэг. Компани нь ажилтны үзүүлсэн үйлчилгээний дагуу компанид үүрэг хариуцлага үүссэнээс найдвартайгаар тооцоолж болох компанийн төлөх ёстой дүнгээр өр төлбөрөө хүлээн зөвшөөрдөг.

ТОГТООСОН ШИМТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.

Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж нь Монгол Улсын Нийгмийн Даатгалын Санд төвлөрүүлэх хуулиар тогтоосон нийгмийн даатгалын шимтгэлээс бүрдэнэ. Тодорхой шимтгэлийн дүн бүхий тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөрт төвлөрүүлэх шимтгэлийг түүнийг төлөх үүрэг хүлээсэн тайлант үеийн зардлаар бүртгэдэг.

НӨӨЦ БА БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Компани өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, уг үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөц шаардлагатай гэдэг нь тодорхой болсон ба үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой болсон үед санхүүгийн байдлын тайланд нөөцийг хүлээн зөвшөөрдөг.

ХУВЬЦААТ КАПИТАЛ**ЭНГИЙН ХУВЬЦАА.**

Энгийн хувьцааг эздийн өмчийн хэсэгт ангилж, бүртгэдэг. Энгийн хувьцаа нэмж гаргахтай холбоотой нэмэгдэл зардлыг татварын нөлөөллийн дараах цэвэр дүнгээр нь эздийн өмчийн бууралтаар хүлээн зөвшөөрдөг.

ХАЛААСНЫ ХУВЬЦАА.

Хувьцаат капиталыг буцаан худалдан авсан үед аливаа татварын нөлөөллийн дараах худалдан авахтай холбоотой гарсан шууд зардлыг багтаасан дүнгээр эздийн өмчийн бууралт гэж бүртгэдэг.

Буцаан худалдан авсан хувьцааг халаасны хувьцаа гэж нэрлэх бөгөөд өмчийн өөрчлөлтийн тайланд халаасны хувьцаа гэж тайлагнадаг. Халаасны хувьцааг дахин борлуулсан эсвэл дахин эргэлтэнд гаргасан үед хүлээн авсан дүнг өмчийн өсөлтөөр бүртгэдэг бөгөөд тухайн ажил гүйлгээтэй холбогдон гарсан өсөлт, бууралтыг нэмж төлөгдсөн капитал гэж толилуулдаг.

ХУВЬЦААТ КАПИТАЛ, НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ БА БУСАД НӨӨЦҮҮД

Эвэргрийн Инвестментс ХХК-тай нэгдсэн талаар Холбогдох эрх бүхий байгууллагуудаас зохих зөвшөөрлүүдийг шат дараатай авсны үндсэн дээр нэгдлийн ажил гүйлгээ 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөр дуусгавар болсон. Эцсийн үе шатанд Эвэргрийн Инвестментс ХХК компанид нэгдсэн бөгөөд компани нь нэгдсэн компаниуд, тэдгээрийн охин компаниудын толгой компани болсон. Нэгдлийн үр дүнд дараах өмчийн дахин зохион байгуулалтыг хийсэн:

2017 оны 8 дугаар сарын 18-ны өдөр компанийн хувьцаа эзэмшигчид нийт 338,127,000 мянган төгрөгөөр капиталыг нэмэгдүүлэх замаар Эвэргрийн Инвестментс ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд нийт 321,305 мянган ширхэг энгийн хувьцааг шинээр гаргасан. Уг капитал нь 32,130 мянган төгрөгийн хувьцаат капитал болон 338,094,870 мянган төгрөгийн нэмж төлөгдсөн капиталаас бүрдсэн.

Нэгдлийн нөөц

Бизнесийн нэгдлийн хүрээнд компанийн шилжүүлсэн төлбөр нь Эвэргрийн Инвестментс ХХК-тай хийсэн нэгдэлд зориулж шинээр гаргасан хувьцаа болно. Өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо бодит үнэ цэнийн 1 дүгээр шатлалын хэмжүүр болох компанийн хувьцааны зах зээлийн үнэ цэнийг ашигласан. Нэмж гаргасан хувьцааны бодит үнэ цэнэ болон хуулийн дагуу бүртгэгдсэн үнэ цэнийн зөрүү болох 112,795,804 мянган төгрөгийг нэгдлийн нөөц гэж бүртгэсэн.

ОРЛОГО

Бараа борлуулалтын орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжиж бүртгэлд тусгадаг. Ингэхдээ компани эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлал өндөр бөгөөд орлого ба өртөг зардлыг бодитоор хэмжих боломжтой байх ёстой.

БАРАА БОРЛУУЛАЛТ.

Бараа агуулахаас ачигдан, худалдан авагчийн талбайд хүргэгдэж, худалдан авагч барааг хүлээн авч, эрсдэл болон өмчлөл нь худалдан авагчид бүрэн шилжсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрдөг. Орлогын дүнд нэмэгдсэн өртгийн албан татвар болон бусад борлуулалтын татварыг оруулдаггүй ба худалдааны хөнгөлөлт, урамшууллыг хассан цэвэр дүн байдаг.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮРЭЭСИЙН ОРЛОГО. Үйл ажиллагааны түрээсийн орлогыг түрээсийн хугацааны туршид төлөгдөх ижил хэмжээний хэсэгчилсэн төлөлтөөр орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Хүлээн авсан түрээсийн хөрөнгийн урамшууллыг түрээсийн нийт зардлын дүнд тооцон түрээсийн хугацааны туршид хүлээн зөвшөөрдөг. Болзошгүй түрээсийн орлогыг тухайн орлогыг олсон тайлант хугацаанд хүлээн зөвшөөрдөг.

БУСАД ОРЛОГО.

Компанийн үндсэн үйл ажиллагаанаас гадна бий болж буй орлогыг бусад орлого гэх бөгөөд тухайн орлогын эдийн засгийн өгөөжийг компани хүртэх магадлалтай ба үүнийг найдвартай хэмжин тодорхойлох боломжтой болсон үед компани бусад орлогыг хүлээн зөвшөөрдөг.

САНХҮҮГИЙН ОРЛОГО БА САНХҮҮГИЙН ЗАРДАЛ

Санхүүгийн орлогод хөрөнгө оруулалтаас хүртэх хүүгийн орлого орно. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцож, орлогын тайланд хуримтлуулан бүртгэдэг.

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардлаас бүрддэг. Зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцож, орлогын тайланд бүртгэдэг.

ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ

Орлогын албан татварын зардал нь тайлант жилийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Тайлант жилийн татвар болон хойшлогдсон татварыг эздийн өмч эсвэл бусад дэлгэрэнгүй орлогоор шууд хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг.

НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ

Компани энгийн хувьцааны хувьд нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр ашиг, алдагдлыг тайлант хугацааны туршид эргэлтэнд байсан энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоонд хуваах замаар нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог.

ХОЛБООТОЙ ТАЛУУД

Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд компанитай холбоотой гэж үзнэ:

- Компанийг хянадаг эсвэл хамтран хянадаг;
- Компанид мэдэгдэхүйц нөлөөлөлтэй;
- Компанийн эсвэл түүний толгой компанийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.

Хувь хүний гэр бүлийн ойр дотны гишүүд гэдэг нь компанитай ажил хэргийн харилцаанд орох явцад хувь хүнд нөлөөлөх эсвэл түүний нөлөөнд автаж болзошгүй гэр бүлийн гишүүд юм.

ТАЙЛБАР ТОЛЬ

ТАЙЛАНТ ҮЕ

Аж ахуйн нэгж, байгууллагын ашиг, алдагдлыг тооцож буй хугацааг хэлнэ. Ерөнхийдөө улирал, жилийг хамруулж авч үзнэ.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Иж бүрэн санхүүгийн тайлан нь санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдэнэ.

ХӨРӨНГӨ

Хөрөнгө гэдэг нь өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд бий болж, байгууллагын мэдэлд орсон бөгөөд ирээдүйд үр өгөөжөө өгөх нөөц, баялаг, хөрөнгө юм.

ББХ-БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгөтэй адил биетээр, бодитоор оршдоггүй хэдий ч эзэмшигчдэдээ давуу тал болон давуу эрхийг олгодог патент, лиценз, зохиогчийн эрх, барааны тэмдэг, нэр төр, гүүдвил гэх мэт удаан хугацаанд үнэ цэнэтэй байх актив (хөрөнгө)-ыг хэлнэ.

ҮХ-ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Байшин, барилга, машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил гэх мэт худалдан борлуулах зориулалтгүй, үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаанд урт хугацаанд ашиглагдах буюу 1 жилээс бага хугацаанд борлогдож мөнгөн хөрөнгө болохгүй хөрөнгийг хэлнэ.

ЭБХ-ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийг хэлнэ.

ЭХ-ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй явуулахад ашиглагдах нэг жил буюу түүнээс бага хугацаанд бэлэн мөнгө болж хувирах хөрөнгийг хэлнэ.

УТЗ-УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ

Ажил үйлчилгээ авахаас өмнө буюу үр дүн нь гарахаас өмнө төлсөн төлбөр

ДАНСНЫ АВЛАГА

Үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил, үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас авах мөнгөн дүн.

БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

3 сараас нэг жилийн хугацаатай хадгаламж, богино хугацаат хөрөнгө оруулалт хамаарна.

МӨНГӨТЭЙ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Үнэ цэнийг нь өөрчлөхөд өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөнд шууд хөрвөх нэгээс гурван сарын хугацаатай хөрөнгө оруулалт юм.

МӨНГӨН СУУРЬТ АРГА

Бэлнээр мөнгө хүлээж авсан үед нь орлогод, бэлнээр мөнгө төлсөн үед нь зардалд бүртгэх нягтлан бодох бүртгэлийн арга.

АККРУЭЛ СУУРЬТ АРГА

Мөнгө хүлээн авсан, эсхүл төлснөөс үл хамааран ажил үйлчилгээний гүйцэтгэлтэй уялдуулан орлогыг олсон, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг хэлнэ.

ХУВЬЦААТ КАПИТАЛ

Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө юм.

ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ

Аж ахуйн нэгжийн үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансны үнэ дахин үнэлгээний үр дүнд өссөн дүнг хэлнэ.

ӨР ТӨЛБӨР

Бусдад төлөх ёстой мөнгө (хувь хүн, компани, эсхүл Засгийн газрын өр байж болно).

УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Нэг жилээс дээш хугацаанд төлөгдөх дотоодын болон гадаадын эх үүсвэр, холбоотой талаас авсан зээлийг хэлнэ.

БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

12 сарын дотор төлбөр нь төлөгдөх өр төлбөрийг хэлнэ.

НДШ-НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг санхүүжүүлэх зорилгоор ажилчид болон ажил олгогчдод ногдуулах татвар.

ОТ-ОРЛОГЫН ТАЙЛАН

Компанийн олсон орлого, гаргасан зардлыг тодорхой хугацаагаар (улирал, жил) тасалбар болгон харуулсан тайлан **БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО** Тайлангийн хугацаанд худалдсан бараа, бүтээгдэхүүн үйлчилгээнийн үйл ажиллагаанаас олсон орлогыг хэлнэ.

БОРЛУУЛАЛТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

Тайлант үед борлуулсан барааны өртгийг хэлнэ.

НИЙТ АШИГ

Байгууллагын тодорхой хугацаан дахь үйл ажиллагааны үр дүнгийн мөнгөн илэрхийлэл буюу бизнес эрхэлж, эрсдэл хүлээсний төлөө авч буй үр өгөөж, компанийн нийт орлогоос бүх мөнгөн болон хийсвэр зардлыг хасч тооцно.

ҮАЗ-ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Бизнес эрхлэхэд гарч буй зардал.

ХТӨА

Хүү татварын өмнөх ашиг

ЦЭВЭР АШИГ

Компанийн орлогоос бүх төрлийн зардал болон татварыг хасаад үлдэж буй ашгийн хэмжээ.

ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ

Орлогын албан татварын зардал нь орлогын албан татварын өмнөх ашиг нь хувиар илэрхийлсэн

ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

Засгийн газраас аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогод ногдуулж буй татвар

МГТ-МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Байгууллагын тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн өөрчлөлтийг харуулсан тайлан

ҮҮАМГ

Үндсэн Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ байгууллагын орлого олох үндсэн үйл ажиллагаанаас орж ирэх мөнгөн хөрөнгийг хэлнэ

ГХО

Гадаадын хөрөнгө оруулалт

APU COMPANY
Absolute. Pure. Unique.

АПУ ХУВЬЦААТ КОМПАНИ
Улаанбаатар хот - 17040, Чингисийн өргөн чөлөө - 14,
Утас: +976 - 7600 2220, Факс: +976 - 11 - 343063
www.apu.mn

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар
сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан
“Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/					
<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>					
<i>Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/</i>		2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр			
<i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i>		Нэр: АПУ ХУВЬЦААТ КОМПАНИ УБГД: 000165753, РД: 2702673 ҮЦКод: АПУ /90/ Утас: 11-344336			
<i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i>		Монголын хөрөнгийн бирж			
<i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i>		Шингэн хүнсний үйлдвэрлэл			
<i>Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо</i>		“Солид Юнити Аудит” ХХК, 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр			
<i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i>		1,064,181,553			
<i>Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i>		Санхүү, тайлагналын албаны дарга Ж.Оюумаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан			
1. Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/					
<i>Санхүүгийн байдлын үзүүлэлт</i>	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эхний үлдэгдэл /дахин тайлагнасан/	Эцсийн үлдэгдэл	
	Хөрөнгө				
	Эргэлтийн хөрөнгө	251,636,753,000	251,636,753,000	351,152,026,000	
	Эргэлтийн бус хөрөнгө	365,575,443,000	364,888,617,000	490,982,398,000	
	Нийт хөрөнгө	617,212,196,000	616,525,370,000	842,134,424,000	
	Өр төлбөр ба эздийн өмч				
	Богино хугацаат өр төлбөр	61,180,857,000	61,180,857,000	129,643,932,000	
	Урт хугацаат өр төлбөр	51,044,831,000	51,044,831,000	78,913,248,000	
	Эздийн өмч	504,986,508,000	504,299,682,000	633,577,244,000	
	Нийт өр төлбөр ба эздийн өмч	617,212,196,000	616,525,370,000	842,134,424,000	
<i>Орлогын тайлан</i>	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эхний үлдэгдэл /дахин тайлагнасан/	Эцсийн үлдэгдэл	
	Борлуулалтын орлого (цэвэр)	678,164,129,000	678,164,129,000	850,239,813,487	
	Борлуулалтын өртөг	(343,229,879,000)	(343,229,879,000)	(478,212,778,487)	
	Нийт ашиг (алдагдал)	334,934,250,000	334,934,250,000	372,027,035,000	
	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	194,759,436,000	194,694,955,000	154,112,211,000	
	Орлогын татварын зардал	(41,073,744,000)	(41,073,744,000)	(28,214,649,000)	
	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	153,685,692,000	153,621,211,000	125,897,562,000	
	Бусад дэлгэрэнгүй орлого	(296,977,000)	(296,977,000)	66,117,907,000	
	Нийт орлогын дүн	153,388,715,000	153,324,234,000	192,015,469,000	
	Толгой компанийн хувьцаа эзэмшигчэд ноогдох	159,421,520,000	159,357,039,000	210,810,663,000	
	Хяналтын эрхгүй хувь оролцоонд ноогдох	(6,032,805,000)	(6,032,805,000)	(18,795,194,000)	

<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>		Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эхний үлдэгдэл /дахин тайлагнасан/	Эцсийн үлдэгдэл
		Эздийн өмч			
	Хувьцаат капитал	106,297,000.00	106,297,000.00	106,297,000.00	106,297,000.00
	Нэмж төлөгдсөн капитал	338,094,870,000.00	338,094,870,000.00	338,094,870,000.00	338,094,870,000.00
	Нэгдлийн нөөц	(112,795,804,000.00)	(112,795,804,000.00)	(112,795,804,000.00)	(112,795,804,000.00)
	Дахин үнэлгээний нөөц	99,774,305,000.00	92,842,146,000.00	92,842,146,000.00	156,566,882,000.00
	Гадаад валютын хөрвүүлгийн нөөц	(43,443,000.00)	(43,443,000.00)	(43,443,000.00)	703,518,000.00
	Хуримтлагдсан ашиг	179,766,462,000.00	186,011,795,000.00	186,011,795,000.00	220,738,413,000.00
	Нийт эздийн өмч	504,902,687,000.00	504,215,861,000.00	504,215,861,000.00	603,414,176,000.00
	Хяналтын эрхгүй хувь оролцоо	83,821,000.00	83,821,000.00	83,821,000.00	30,163,068,000.00
	Нийт дүн	504,986,508,000.00	504,299,682,000.00	504,299,682,000.00	633,577,244,000.00
<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>		Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эхний үлдэгдэл /дахин тайлагнасан/	Эцсийн үлдэгдэл
		Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	181,646,656,000.00	181,563,796,000.00	181,563,796,000.00
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(65,593,724,000.00)	(65,510,864,000.00)	(65,510,864,000.00)	(92,776,665,000.00)
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(102,769,622,000.00)	(102,769,622,000.00)	(102,769,622,000.00)	(60,638,967,000.00)
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	13,283,310,000.00	13,283,310,000.00	13,283,310,000.00	(40,769,996,000.00)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	64,059,243,000.00	64,059,243,000.00	64,059,243,000.00	77,277,746,000.00
	Мөнгөн хөрөнгийн үнэ цэнийн бууралт болон валютын ханшийн өөрчлөлт	(64,807,000.00)	(64,807,000.00)	(64,807,000.00)	1,857,392,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	77,277,746,000.00	77,277,746,000.00	77,277,746,000.00	38,365,142,000.00
1.1.	<i>Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт</i>				
	- Хавсралтаар оруулав.				
1.2.	<i>Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/</i>				
	- Байхгүй.				
2.	<i>Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл</i>				
2.1.	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	Харьцаанууд	2021	2021 /дахин тайлагнасан/	2022
		Нийт ашгийн хувь	49%	49%	44%
		Үйл ажиллагааны ашгийн хувь	29%	29%	18%
		Цэвэр ашгийн хувь	23%	23%	15%
		Өөрийн хөрөнгийн өгөөж	30%	30%	21%
		Нэгж хувьцаанд ногдох ашиг	150,256.12	150,195.46	136,120.56
2.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>	Харьцаанууд	2021	2021 /дахин тайлагнасан/	2022
		Эргэлтийн харьцаа	4.11	4.11	2.71
		Түргэн хөрвөх чадварын харьцаа	1.80	1.80	0.77
		Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа	0.22	0.22	0.33
2.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</i>	<p>Гадаад орчны зүгээс Орос, Украйны дайн эдийн засаг, хил гааль болон татан авалтын процесс-т тодорхой нөлөөлөл үзүүлж байна.</p> <p>Түүхий эд материалын тасалдал гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор боломжит өөр бэлтгэн нийлүүлэгчдийг хайх, урьдчилсан захиалгуудыг өгөх, ханшийн өсөлтөөс үүдсэн үнийн өсөлтийг зохицуулах, мөнгөн урсгалд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.</p> <p>Зах зээлд эзлэх хувь хэмжээ болон бүтээгдэхүүн үйл ажиллагааны нэр төрөлд өөрчлөлт ороогүй болно.</p>			

2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй болно.																																																																																						
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	<p>АПУ ХК нь 2022 онд нэмэлтээр санхүүжилт, зээл аваагүй болно. ХААН Банктай 2020 онд байгуулсан 30 тэрбум төгрөгийн зээлийн эрхийн хугацааг 2 жилээр сунгаж, 30 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан.</p> <p>ХААН Банктай 2020 онд байгуулсан 30 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл 2023 оны 9-р сараас эхлэн эргэн төлж эхэлнэ. 2022 онд зээлийн эргэн төлөлт хийгдээгүй. Дээрх зээлүүдийн барьцаа хөрөнгүүдэд 2022 онд өөрчлөлт ороогүй болно.</p>																																																																																						
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/																																																																																							
	Их хэмжээний хэлцэл: Их хэмжээний хэлцэл байхгүй Сонирхлын зөрчилтэй хэлцэл: Сонирхлын зөрчилтэй хэлцлийг аудитлагдсан санхүүгийн тайлангийн холбоотой талуудын гүйлгээний жагсаалтаар тодруулсан. Хавсралтаар оруулав.																																																																																							
4.	Цалин урамшууллын мэдээлэл																																																																																							
	<p>ТУЗ-ийн цалин, урамшуулал: ТУЗ-ийн дарга болон гишүүдэд сар бүр тогтмол цалин олгодог ба нэмэлт урамшуулал олгодоггүй.</p> <table border="1" data-bbox="296 1155 1520 1603"> <thead> <tr> <th rowspan="2">№</th> <th rowspan="2">ТУЗ-ийн гишүүн</th> <th colspan="2">Сарын үндсэн цалин (төг)</th> <th rowspan="2">Олговол зохих нийт цалин (төг)</th> <th rowspan="2">НДШ, ХХОАТ суутгал (төг)</th> <th rowspan="2">Гарт олгосон нийт цалин</th> </tr> <tr> <th>1 – 4-р сар</th> <th>5 – 12-р сар</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>П.Батсайхан</td> <td>6,000,000</td> <td>10,000,000</td> <td>104,000,000</td> <td>15,525,680</td> <td>88,474,320</td> </tr> <tr> <td>2</td> <td>Б.Батбаяр</td> <td>4,500,000</td> <td>6,500,000</td> <td>70,000,000</td> <td>12,125,680</td> <td>57,874,320</td> </tr> <tr> <td>3</td> <td>Сергей Громов</td> <td>4,500,000</td> <td>6,500,000</td> <td>70,000,000</td> <td>12,125,680</td> <td>57,874,320</td> </tr> <tr> <td>4</td> <td>Кеннет Чу</td> <td>4,500,000</td> <td>6,500,000</td> <td>70,000,000</td> <td>19,796,000</td> <td>50,204,000</td> </tr> <tr> <td>5</td> <td>Сэн И-Ин</td> <td>4,500,000</td> <td>6,500,000</td> <td>70,000,000</td> <td>19,796,000</td> <td>50,204,000</td> </tr> <tr> <td>6</td> <td>Том Холланд</td> <td>4,500,000</td> <td>-</td> <td>18,000,000</td> <td>5,532,000</td> <td>12,468,000</td> </tr> <tr> <td></td> <td>Д.Миезгомбо</td> <td>-</td> <td>6,500,000</td> <td>52,000,000</td> <td>8,617,120</td> <td>43,382,880</td> </tr> <tr> <td>7</td> <td>Ё.Гэрэлчулуун</td> <td>4,500,000</td> <td>6,500,000</td> <td>70,000,000</td> <td>11,218,480</td> <td>58,781,520</td> </tr> <tr> <td>8</td> <td>Ж.Үнэнбат</td> <td>4,500,000</td> <td>6,500,000</td> <td>70,000,000</td> <td>12,125,680</td> <td>57,874,320</td> </tr> <tr> <td>9</td> <td>О.Одбаяр</td> <td>4,500,000</td> <td>6,500,000</td> <td>70,000,000</td> <td>12,125,680</td> <td>57,874,320</td> </tr> <tr> <td></td> <td>НИИТ</td> <td>42,000,000</td> <td>62,000,000</td> <td>664,000,000</td> <td>128,988,000</td> <td>535,012,000</td> </tr> </tbody> </table>		№	ТУЗ-ийн гишүүн	Сарын үндсэн цалин (төг)		Олговол зохих нийт цалин (төг)	НДШ, ХХОАТ суутгал (төг)	Гарт олгосон нийт цалин	1 – 4-р сар	5 – 12-р сар	1	П.Батсайхан	6,000,000	10,000,000	104,000,000	15,525,680	88,474,320	2	Б.Батбаяр	4,500,000	6,500,000	70,000,000	12,125,680	57,874,320	3	Сергей Громов	4,500,000	6,500,000	70,000,000	12,125,680	57,874,320	4	Кеннет Чу	4,500,000	6,500,000	70,000,000	19,796,000	50,204,000	5	Сэн И-Ин	4,500,000	6,500,000	70,000,000	19,796,000	50,204,000	6	Том Холланд	4,500,000	-	18,000,000	5,532,000	12,468,000		Д.Миезгомбо	-	6,500,000	52,000,000	8,617,120	43,382,880	7	Ё.Гэрэлчулуун	4,500,000	6,500,000	70,000,000	11,218,480	58,781,520	8	Ж.Үнэнбат	4,500,000	6,500,000	70,000,000	12,125,680	57,874,320	9	О.Одбаяр	4,500,000	6,500,000	70,000,000	12,125,680	57,874,320		НИИТ	42,000,000	62,000,000	664,000,000	128,988,000	535,012,000
№	ТУЗ-ийн гишүүн	Сарын үндсэн цалин (төг)			Олговол зохих нийт цалин (төг)	НДШ, ХХОАТ суутгал (төг)				Гарт олгосон нийт цалин																																																																														
		1 – 4-р сар	5 – 12-р сар																																																																																					
1	П.Батсайхан	6,000,000	10,000,000	104,000,000	15,525,680	88,474,320																																																																																		
2	Б.Батбаяр	4,500,000	6,500,000	70,000,000	12,125,680	57,874,320																																																																																		
3	Сергей Громов	4,500,000	6,500,000	70,000,000	12,125,680	57,874,320																																																																																		
4	Кеннет Чу	4,500,000	6,500,000	70,000,000	19,796,000	50,204,000																																																																																		
5	Сэн И-Ин	4,500,000	6,500,000	70,000,000	19,796,000	50,204,000																																																																																		
6	Том Холланд	4,500,000	-	18,000,000	5,532,000	12,468,000																																																																																		
	Д.Миезгомбо	-	6,500,000	52,000,000	8,617,120	43,382,880																																																																																		
7	Ё.Гэрэлчулуун	4,500,000	6,500,000	70,000,000	11,218,480	58,781,520																																																																																		
8	Ж.Үнэнбат	4,500,000	6,500,000	70,000,000	12,125,680	57,874,320																																																																																		
9	О.Одбаяр	4,500,000	6,500,000	70,000,000	12,125,680	57,874,320																																																																																		
	НИИТ	42,000,000	62,000,000	664,000,000	128,988,000	535,012,000																																																																																		
	<p>Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал: Гүйцэтгэх захиралд ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан үндсэн цалин болон дараах гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу богино хугацааны урамшуулал олгодог ба 2022 онд Гүйцэтгэх захирлын үндсэн цалинд өөрчлөлт ороогүй.</p>																																																																																							


Компанийн зорилт	Хэмжүүр	Зорилт	Эзлэх жин
Борлуулалтын орлого	Тухайн оны бизнес төлөвлөгөөтэй харьцуулснаар хэмжигдэнэ.	100%	25%
Хүү, татварын өмнөх ашиг	Тухайн оны бизнес төлөвлөгөөтэй харьцуулснаар хэмжигдэнэ.	100%	25%
Зардлын хэмнэлт	Нийт зардал хэмнэсэн байдлаар (тухайн оны төсвийн хэмнэлт болон FORCE төслийн хэмнэлт)	100%	25%
Хүн ба байгууллагын хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэл болон байгууллагын соёлыг сайжруулах ажлуудын үр дүн	<p>80% нь хүн ба байгууллагын хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлээс хэмжигдэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Гол ажилтнуудыг тодорхойлох, залгамж халааны бодлого, процессын ажлууд - Гүйцэтгэлийн системийн хэрэгжүүлэлт, гүйцэтгэлийн үнэлгээ - Сургалт хөгжлийн бодлогод холбогдох ажлуудын хэрэгжилт - Гол ажлын байруудад чадвартай ажиллах хүчнийг ажиллуулах, чадавхжуулах <p>20% нь Байгууллагын соёлын судалгааны үр дүнгийн дагуу сайжруулах ажлын төлөвлөгөө ба судалгааны дүн өссөн байдлаар хэмжигдэнэ.</p>	100%	25%

5. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

АПУ ГРУПП КОМПАНИЙН БҮТЭЦ

APU COMPANY

Absolute. Pure. Unique.



Хараат компани

Бүтцэд гарсан өөрчлөлт:

Экспортын үйл ажиллагааг тэлэх зорилгоор 100%-ийн хөрөнгө оруулалттай охин компани болох Эйпиюү трейд (Inner Mongolia Airiyou Trade) ХХК-ийг БНХАУ-ын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулж, 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр бүртгүүлсэн.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

Монголын хөрөнгийн бирж (цаашид “МХБ” гэх)-ийн Гүйцэтгэх захирлын 2022.06.09-ний өдрийн А/58 тушаалаар баталсан аргачлалын дагуу Компаниас Кодексийн хэрэгжилтийн үнэлгээг анх 2022.06.16-ны өдөр хийж, МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлсэн.

Улмаар эхний үнэлгээнээс хойш 2022 оны үйл ажиллагааны тайлан бэлтгэх өдөр хүртэл хэрэгжүүлсэн ажлыг дүгнэн, 2023.04.01-ний өдрийн байдлаар өөрийн үнэлгээг давтан хийж, үнэлгээний нэгдсэн үр дүнг 2022.06 сарын үнэлгээтэй харьцуулсан байдлаар дор танилцуулав.

Компанийн засаглалын кодексийн нэгдсэн үнэлгээний дүн:

№	Гарчиг	2022.06.16-ны өдрийн байдлаар			2023.04.01-ний өдрийн байдлаар			2022/2023 өсөлт
		Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь	
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	9	75%	12	12	100%	25%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	8	80%	10	9	90%	10%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%	6	6	100%	0%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	5	83%	6	6	100%	17%
5	Эрсдэлийн удирдлага	8	6	75%	8	7	88%	13%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	3	50%	6	6	100%	50%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	6	75%	8	8	100%	25%
8	Компанийн соёл	6	3	50%	6	6	100%	50%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	8	80%	10	8	80%	0%
	Нэгдсэн дүн	72	54	75%	72	68	94%	19%
		2. Дунд засаглалтай			1. Засаглал хэвийн буюу эрсдэлгүй			1 түвшин ахив.

АПУ ХК-ийн засаглалын нэгдсэн үнэлгээ 94% буюу “Засаглал хэвийн буюу эрсдэлгүй” түвшинд үнэлэгдлээ.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

АПУ ХК-ийн эрх барих дээд удирдлага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022.04.29-ний өдөр Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандийн гудамж 39, Корпорейт Хотел энд Конвеншн Цэнтрийн 4 давхарт байрлах Концерт холл танхимд 94.33%-ийн ирцтэй хуралдаж, дараах шийдвэрүүдийг гаргав. Үүнд:

- 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан “АПУ групп компани 2021 онд тавьсан зорилтуудаа бүрэн биелүүлж, амжилттай ажилласан” хэмээх дүгнэлтийг батлав.

- ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгов. ТУЗ-ийн ердийн гишүүдээр П.Батсайхан, Б.Батбаяр, Сергей Громов, Д.Миеэгомбо, Кеннет Чу, Сэн И-Ин, хараат бус гишүүдээр Ё.Гэрэлчулуун, О.Одбаяр, Ж.Үнэнбат нарыг 3 жилийн хугацаатай сонгов.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ (ТУЗ)

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт ТУЗ компанийг удирддаг.

ТУЗ-ийн дараах бүрэлдэхүүн Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн дотоод дүрэм, журамд заасан АПУ ХК-ийн ТУЗ-ийн болон түүний охин, хараат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлж ажиллав.

Тайлант хугацаанд 2022.04.29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн бүрэн эрхийг дуусгавар болгож, шинэ бүрэлдэхүүнийг сонгосноор дараах өөрчлөлт орсон:

1. ТУЗ-ийн ердийн гишүүнээр Томас Холландын оронд Доржийн Миеэгомбо сонгогдов.
2. ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Өлзийдэлгэрийн Батбаярын оронд түр томилогдсон Одончимэдийн Одбаярыг нөхөн сонгов.

ТУЗ-ийн бүрэлдэхүүн:

ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дарга

ПҮРЭВИЙН БАТСАЙХАН (Инженер мэргэжилтэй)

Шунхлай холдинг ХХК-ийн Ерөнхийлөгч

2002 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн дарга

Хувьцаа эзэмшил: 0.08%



ТУЗ-ийн ердийн гишүүн

БҮРЭНТОГТОХЫН БАТБАЯР (Эдийн засагч мэргэжилтэй)

Шунхлай групп ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал

2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

Хувьцаа эзэмшил: 0.05%



ТУЗ-ийн ердийн гишүүн

СЕРГЕЙ ГРОМОВ (Инженер мэргэжилтэй)

Монгол Даатгал ХК-ийн ТУЗ-ийн дарга

2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

Хувьцаа эзэмшил: 0.00%



ТУЗ-ийн ердийн гишүүн

КЕННЕТ ЧУ (Нягтлан бодогч, менежмент мэргэжилтэй)

Хайнекен Азиа Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийг хариуцсан Гүйцэтгэх захирал

2018 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

Хувьцаа эзэмшил: 0.00%



ТУЗ-ийн ердийн гишүүн

СЭН И-ИН (Хуульч мэргэжилтэй)

Хайнекен Азиа Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийн Хууль эрхзүй хариуцсан захирал

2020 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

Хувьцаа эзэмшил: 0.00%



ТУЗ-ийн ердийн гишүүн

ДОРЖИЙН МИЕЭГОМБО (Хуульч мэргэжилтэй)

“ЁС” ХХН-д зөвлөх

2022 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

Хувьцаа эзэмшил: 0.00%



ТУЗ-ийн хараат бус гишүүн

ЁНДОН-ОЙДОВЫН ГЭРЭЛЧУЛУУН (Эдийн засагч мэргэжилтэй)

Нээлттэй хот ТББ-ын үүсгэн байгуулагч

2017 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

Хувьцаа эзэмшил: 0.00%



ТУЗ-ийн хараат бус гишүүн

ОДОНЧИМЭДИЙН ОДБАЯР (Багш, эрх зүйч мэргэжилтэй)

Ард даатгал ХК, Ард холдинг ХХК, Монгол шуудан ХК-уудын ТУЗ-ийн гишүүн

2021 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

Хувьцаа эзэмшил: 0.00%



ТУЗ-ийн хараат бус гишүүн

ЖИГЖИДИЙН ҮНЭНБАТ (Эдийн засагч мэргэжилтэй)

2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

Хувьцаа эзэмшил: 0.00%



ТУЗ-ийн ажлын тайлан

ТУЗ нь 2022 онд танхимаар, танхим-цахим хосолсон, эчнээ санал хураалтын хэлбэрээр нийт 10 удаа 100%-ийн ирцтэй хуралдав.

№	Огноо	Ирц
1	2022.01.25	100%
2	2022.02.17	100%
3	2022.03.18	100%
4	2022.04.21	100%
5	2022.05.06	100%
6	2022.05.18	100%

7	2022.08.03	100%
8	2022.10.12	100%
9	2022.10.24	100%
10	2022.12.07	100%
	Нийт	100%

Дээрх хурлаар нийт 52 тогтоол шийдвэр гаргасныг дэлгэрэнгүй үзүүлбэл:

№	Групп компани шийдвэрийн төрөл	Баталсан тогтоолын тоо
1	АПУ ХК ТУЗ-ийн хурлын тогтоол	25
2	АПУ Дэйри ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	6
4	АПУ Трейдинг ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	4
5	М Би Си Азиа Пасифик ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	4
6	СББ Трейд ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	4
7	Спирт бал бурам ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	4
8	ОХУ-ын Гранд ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	2
9	ОХУ-ын Гранд Ист ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	1
10	БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эйпиюү трейд ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	2
	Нийт	52

ТУЗ-ийн дэргэдэх хороод

ТУЗ-ийн хороод	Аудитын хороо	Нэр дэвшүүлэх хороо	Цалин урамшууллын хороо
Бүрэлдэхүүн	Ж.Үнэнбат (Хорооны дарга) Сэн И-Ин О.Одбаяр	О.Одбаяр (Хорооны дарга) П.Батсайхан Ё.Гэрэлчулуун	Ё.Гэрэлчулуун (Хорооны дарга) Ж.Үнэнбат Кеннет Чу
Хурал	3 удаа, тус бүр 100%-ийн ирцтэй хуралдаж, дараах асуудлаар санал, шийдвэр гаргав. Үүнд: 1. Групп компанийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын байгууллагын дүгнэлттэй танилцах, 2. Групп компанийн хэмжээнд 2022 оны санхүүгийн тайланд хийх аудитын байгууллага болон аудитын ажлын хөлсний хэмжээг санал болгох, 3. Дотоод аудитын нэгжийн удирдлагыг томилох санал гаргах.	1 удаа 100%-ийн ирцтэйгээр хуралдаж, дараах асуудлаар шийдвэр гаргав: 1. 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг нэр дэвшүүлэх	1 удаа 100%-ийн ирцтэйгээр хуралдаж, дараах асуудлаар санал гаргав: 1. ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэх

б. Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл

ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛСИЙН НӨЛӨӨЛӨЛ, ТҮҮНД АВЧ БҮЙ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Дэлхийн хэмжээнд

- **САНЦ, БОЕКОТТ, ХЯЭГААРЛАЛТУУДАД МОНГОЛ УЛС ӨРТӨХ**
- **ЭДИЙН ЗАСГИЙН УНАЛТ**
Өр, хүүгийн дарамт
Инфляцын дарамт
Валютын ханшийн хэлбэлзэл
Хөрөнгө оруулалт хумигдах
- **БАЙГАЛИЙН ГАМШИГ, ЦАГ УУРЫН ӨӨРЧЛӨЛТҮҮД**
Бараа таваарын үнийн өсөлт, шок
Байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр ТЭМ тасалдах
- **ХҮНИЙ НӨӨЦ, НИЙГМИЙН ХЯМРАЛ**
Халдварт өвчний тархалт
Ажиллах хүчний дутагдал
Нийгмийн сөрөг хандлага
Хэрэгжэгчийн худалдан авах чадварын бууралт
- **КИБЕР ЭРСДЭЛ**
Кибер халдлагууд

Компанийн хэмжээнд

- **ӨРТӨГ ЗАРДЛЫН ӨСӨЛТ**
- **НИЙЛҮҮЛЭЛТ ТЭМ ТАСАЛДАЛ**
- **ХҮНИЙ НӨӨЦ, АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДУТАГДАЛ**
- **НИЙГМИЙН ЭМЗЭГ БАЙДАЛ, СӨРӨГ ХАНДЛАГА**
- **КИБЕР ХАЛДЛАГА**

● Эдийн засаг/Саяхуу ● Байгаль орчин ● Нийгэм ● Дотоод ● Геополитик

ТОП ЭРСДЭЛҮҮД

ӨРТӨГ ЗАРДЛЫН ӨСӨЛТ

НИЙЛҮҮЛЭЛТ ТЭМ ТАСАЛДАЛ

ХҮНИЙ НӨӨЦ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДУТАГДАЛ

НИЙГМИЙН ЭМЗЭГ БАЙДАЛ, СӨРӨГ ХАНДЛАГА

КИБЕР ЭРСДЭЛ

ЮУ ТОХИОЛДОЖ БОЛОХ ВЭ?

Орос Украины үргэлжилсэн зөрчилдөөнт байдлаас үүдэлтэй гол бараа таваарын нийлүүлэлтийн саатал, тээвэр логистикийн асуудал нь үнийн хөөргөдлийг бий болгож, улмаар бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өртгийг нэмэгдүүлэн хүлээгдэж буй ашиг орлогын өсөлтийг сааруулахаар байна. Мөн инфляцтай холбоотойгоор амьжиргааны зардал өсөж хэрэгжэгчийн худалдан авах чадварт сөргөөр нөлөөлөн бүтээгдэхүүний үнийн бодлогыг харилцан зохист түвшинд барихад хүндрэл үүсгэх эрсдэлтэй.

Геополитикийн асуудлаас улбаатай тээвэр логистикийн саатаа, хил гаалийн хягааралтууд үүсэж, үүний улмаас компанийн ТЭМ цаг хугацаанд ирэхгүй байх, бэлтгэн нийлүүлэгчтэй хийх гэрээ, төлбөр тооцоо шилжүүлэг хойшлох, агуулахын зай талбай ашиглалтын ачааллыг нэмэх зэрэг борлуулалт, үйлдвэр төлөвлөлтөд томоохон сорилтыг бий болгож байна.

Дэлхий дахинд тулгарсан цар тахав түүнээс үүдэн сөрөг үр дагаврууд нь нийт ажиллах хүчний бие физиологийн болоод сэтгэл зүйн хямралуудыг дагуулж бүтээмж сулрах, ажлаас халсрах хам шинж илрэх, ажлаас гарах орох урсгал нэмэгдэх, мөн шинэ үеийн залуусын зан төлөвт уялдуулан удирдах болон хамтран ажиллах арга барилаа өөрчлөх шаардлага үүсэх зэрэг хүнтэй холбоотой эрсдэлүүдийг дагуулж үүнд ихээхэн анхаарлаа хандуулах шаардлага тулгарч байна.

Ядуурал, гэмт хэрэг, хүчирхийлэл зэрэг нийгмийн томоохон асуудлуудыг хөндөхдөө компанийн үйл ажиллагаатай холбох байдлаар олон нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэр хүндэд шууд халдах, сөрөг мессежийг түгээх, нэр хүндэд томоохон нөлөөлөл үзүүлэх санаатай үйлдлүүд нэмэгдэх магадлал өндөр байна.

Техник технологийн хурдацтай өөрчлөлт, шинэчлэлт, цахим шилжилтүүд нь өдөр тутмын үйл ажиллагааг хөнгөөчилж, шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх олон давуу тал, боломжийг бий болгож байгаа хэдий ч кибер халдлагууд болох phishing, scareware, Scam зэрэг сэжигтэй имейл ирэх залиланд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

ЭРСДЭЛИЙГ УДИРДАХЫН ТУЛД БИД ЮУ ХИЙЖ БАЙНА ВЭ?

Энэ чиглэлд эрсдэлийг бууруулах/сулруулах стратегийг баримталж байгаа ба брэнд портфолго менежментийг оновчтой, санхүүгийн сахилга баттай, ухаалаг зардлын хэмнэлтийг хэрэгжүүлэх, компанийн хэмжээнд зардлын хэмнэлтийн санал санаачилгыг тогтмол хүлээн авч, бодитоор хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэ төрлийн эрсдэлээс зайлсхийхийн тулд гэнэтийн ямар ч өөрчлөлтөд бэлэн, уян хатан менежментэй байх түүнтэй уялдан бүтэцтэй болох, бизнесийн тогтвортой үйл ажиллагааны төлөвлөгөөг баримтлан үйлдвэр төлөвлөлтийн цэгц үйл ажиллагааг оновчтой ажлуудыг хийж байна.

Ажилтнуудын сэтгэл зүйн эрүүл мэндэд чиглэсэн олон төсөл хөтөлбөр, сургалт уулзалтуудыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд "APU LIFE", "GOOD PLACE TO WORK". Мөн хүн төвтэй бодлогын хүрээнд сургалт хөгжлөөр тасралтгүй хангах зорилгоор сургалтын академиудыг үүсгэн байгуулсан.

Хуулийн шинэчлэлтэй холбоотойгоор архи, согтууруулах ундааны спиртийн градусыг шат дараатай бууруулах арга хэмжээг авч ажиллахын зэрэгцээ соёлтой хэрэглээг таниулан сурталчлах олон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд чиглэн ажиллаж байна.

Компанийн хэмжээнд ISO27001:2013 Мэдээллийн системийн чанарыг тогтолцоог нэвтрүүлэхээр бэлтгэж байгаа ба нийт ажилтнуудыг сэрэмжтэй байх тал дээр сургалт, мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна.

7.

Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид*

Д/д	Хувьцаа эзэмшигч	2021 оны эцэс		2022 оны эцэс	
		Хувьцааны тоо ширхэг	Нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь
1	Шунхлай Холдинг ХХК	596,229,642	56.03	596,229,642	56.03
2	Heineken Asia Pacific Pte Ltd	266,091,981	25.00	266,091,981	25.00
3	Steppe Beverage KFT	142,870,636	13.43	115,769,993	10.88
4	Бусад	58,989,294	5.54	86,089,937	8.09

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо*



* ҮЦГХТ ХХК-аас гаргасан 2022.12.31-ний өдрийн байдлаарх үнэт цаасны төвлөрлийн судалгааны мэдээлэл

8.


Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл

Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.

9.

Ногдол ашигийн мэдээлэл

Компанийн ногдол ашиг төлөлтийн харьцааг сүүлийн таван жилээр дараах хүснэгтэд үзүүлэв.



ТУЗ-өөс 2022 онд Компанийн хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд эхний хагас жилд 45 төгрөг, сүүлийн хагас жилд 44 төг, нийлбэр дүнгээр 89 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн болно.

Ногдол ашгийн хуваарилалт (сүүлийн 5 жил)

Тайлант хугацаа	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төг)	ТУЗ-өөс ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн өдөр	Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдөр
2018 он	46	2019.02.19	2019.04.04
2019 он	71	2020.02.14	2020.03.23
2020 он	95		
Үүнээс: I хагас жил	37.5	2020.08.13	2020.09.02
II хагас жил	57.5	2021.02.15	2021.03.31
2021 он	106		
Үүнээс: I хагас жил	46	2021.08.16	2021.09.03
II хагас жил	60	2022.02.17	2022.04.08
2022 он	89		
Үүнээс: I хагас жил	45	2022.08.03	2022.08.22
II хагас жил	44	2023.02.13	2023.04.07



Ногдол ашгийн төлбөрийг нийт хувьцааны таваас доош хувийг эзэмшигчдэд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар зуучлуулан, таваас дээш хувийг эзэмшигчдэд компаниас шууд төлөх замаар мөнгөн хэлбэрээр олгож байна.

10.

Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл

АПУ ХК тогтвортой хөгжих үндсээ бататгах хүрээнд 2022 онд байгаль орчин, нийгэм, засаглалын нөлөөллөө сайжруулах томоохон ажлуудыг эхлүүлж, урт хугацааны ач холбогдолтой ажлуудаа үргэлжлүүлэн гүйцэтгэлээ.

- ✓ Түүхий нүүрсний хэрэглээг үе шаттай халах, агаарын бохирдлыг бууруулах, эрчим хүч хэмнэх ажлыг Tiger шар айрагны үйлдвэрийн хэмжээнд уурын зуух төслөөр дамжуулан нэвтрүүлсэн. Ингэснээр 3000тн түүхий нүүрсийг хэрэглээнээсээ халах боломж бүрдлээ.
- ✓ Хаягдлаа эргүүлэн авч, дахин амьдруулахаас гадна хог хаягдлын хэмжээгээ системтэйгээр бууруулах үйлсэд мөн хүч түрэн ажилласан болно. Тухайлбал “Шилээ дахин амьдруулъя” төслийн хүрээнд 2022 онд хэрэглэгч, түгээгч, тээвэрлэлтийн байгууллага болох бүхий л оролцогч талыг хамруулан шилийг онцгой үнээр эргүүлэн авч харилцан эдийн засгийн өгөөжийг хүртэх зарчмаар нийт 960 гаруй агентыг төсөлд нэгтгэж, шилний эргэлтийг 3 дахин нэмэгдүүлж чадлаа.
- ✓ Компанийн засаглалыг бэхжүүлэх зорилгоор засаглалын дүрэм, журмаа 2022 онд шинэчлэн батлах нүсэр ажлыг шуурхайлан гүйцэтгэж, хувьцаа эзэмшигчдээс гадна бүх оролцогч талуудын тэгш байдал, ашиг сонирхлыг хамгаалах сууриа бататгалаа.
- ✓ Хүртгэмжтэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хариуцлагатай хэрэглээг сурталчлах, олон нийтийн эрүүл мэнд, чөлөөт цагийг спортоор дамжуулан дэвжээх ажлууд мөн тасралтгүй урагшилж байна.
- ✓ Компанийн дараагийн 100 жилийн тэргүүн чиг, зорилтот нөлөөллийг тодорхойлох Тогтвортой хөгжлийн стратегийг боловсруулах ажлын эхний шатыг 2022 онд эхлүүлсэн ба 2023 онд гол оролцогч талуудын оролцоонд тулгуурлан эцэслэн батлуулахаар ажиллаж байна.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ц.Эрдэнэбилэг
Албан тушаал: "АПУ" ХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



(Тамга/тэмдэг)

Овог, нэр: Э.Мөнхтогтох
Албан тушаал: "Солид Юнити Аудит" ХХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ч.Ариунсан
Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:

A handwritten signature in black ink, consisting of stylized cursive letters.